

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК
(хаалттай Хувьцаат Компани)

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн тайлан

(Хараат бус аудиторын тайлангийн хамт)

Товчилсон үгсийн тайлбар

ЗМТ	Зээлийн мэдээллийн төв ХХК
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ИЗББ	Ипотекийн зээлээр баталгаажсан бонд
ҮЦСК	Үнэт цаас санхүүжилтийн корпораци
ЖДБ	Жижиг дунд бизнес
ТЗК	Тусгай зориулалтын компани
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
БҮЦ	Бодит үнэ цэн
ХӨ	Хорогдуулсан өртөг
ААБҮЦ	Ашиг алдагдлаарх бодит үнэ цэн
БДОБҮЦ	Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэн
PD	Дефолт болох магадлал
LGD	Дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ
EAD	Дефолт болсон үеийн дүн
ХК	Хувьцаат Компани (хаалттай)

Агуулга

1.	Тайлагнагч аж ахуйн нэгж.....	11	19.	Үндсэн хөрөнгө.....	44
2.	Тайлан бэлтгэсэн үндэслэл.....	11	20.	Биет бус хөрөнгө	46
3.	Шинэ ба шинэчлэгдсэн стандартууд, тайлбарууд.....	16	21.	Гүүдвил.....	46
4.	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд	17	22.	Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр	47
5.	Хүүний орлого ба зардал.....	35	23.	Бусад хөрөнгө.....	47
6.	Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (зардал).....	36	24.	Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	47
7.	Арилжааны цэвэр орлого	36	25.	Харилцагчдын харилцах, хадгаламж.....	48
8.	ААБҮЦ-ээр хэмжигдэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн бусад орлого (зардал)	36	26.	Репо хэлцэл.....	48
9.	Бусад орлого ба зардал	37	27.	Зээлээр авсан санхүүжилт	48
10.	Хүний нөөцийн зардал	37	28.	Бусад өр төлбөр.....	50
11.	Үйл ажиллагааны бус зардал	37	29.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	50
12.	Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бүүралтын (гарз) эсвэл буцаалт	38	30.	Хувьцаат капитал ба нөөц	51
13.	Орлогын албан татварын зардал	38	31.	Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн.....	53
14.	Бэлэн ба Монголбанк дахь мөнгө.....	39	32.	Болзошгүй өр төлбөр ба үүрэг амлалт	56
15.	Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	40	33.	Хөрөнгө ба өр төлбөрийн хугацааны шинжилгээ	58
16.	Хөрөнгө оруулалт	41	34.	Холбоотой талуудын тодруулга	60
17.	Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	42	35.	Эрсдэлийн удирдлага	62
18.	Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	42	36.	Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа.....	82
			37.	Тайлант үеийн дараах үйл явдал	83
			38.	Орчуулга.....	83

Тээвэр хөгжлийн банк ХК

Банкны мэдээлэл

Регистрийн дугаар

2078201

Албан ёсны хаяг

Тээвэр Хөгжлийн Банк ХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Олимпийн гудамж,
Шангри-Ла оффис, 15 дугаар давхар

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
хувьцаа эзэмшигчид

П.Раднаабазар
Г.Минжин
Б.Батгэрэл
Б.Гантуяа
Ө.Ганболд
Д.Оюунгэрэл
Инфраструкчер ХХК

Төлөөлөн Удирдах Зөвлөл

П.Даваа
Р.Базармаа
Б.Энэрэлт
Б.Эрдэнэбаяр
З.Мөнхзаяа
Д.Ашидмаа
Б.Оюунцацрал
Т.Батмагнай
Г.Цогтгэрэл

Гүйцэтгэх захирал

Санхүү хариуцсан захирал

Б.Энэрэлт
Ц.Болор

Хараат бус аудитор

БДО Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Нарны зам-62, ЮНСЕКО-гийн гудамж
Юнион Бюлдинг В блок, 1502 тоот

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Тээвэр Хөгжлийн Банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны удирдлага 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж тайлагнасан болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн тайланг тодруулга 2-оос 4-т дурдсан шаардлагуудад нийцсэнийг баталгаажуулах боломжийг бүрдүүлж, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлэх зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, түүштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас Тээвэр Хөгжлийн Банк ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Б.ЭНЭРЭЛТ
Гүйцэтгэх захирал



Ц.БОЛОР
Санхүү хариуцсан захирал

Монгол Улс,
Улаанбаатар хот

2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тээвэр Хөгжлийн Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Санал дүгнэлт

Тээвэр Хөгжлийн Банк ХК ('Банк') -ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2022 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЁЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартын багтаасан) болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу банкнаас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Бусад асуудлууд

Банкны 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд өөр аудитор аудит хийсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын тайланд өөрчлөлтгүй дүгнэлт илэрхийлж 2022 оны 03 сарын 28-ний өдөр гарын үсэг зурсан.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн тасралтгүй байх зарчим ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг тасралтгүй үйл ажиллагаа үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Khursid Alan
КУРШИД АЛАМ
БДО Аудит ХХК
1502 тоот, 15-р давхар, Юнион Бюлдинг, Б Блок
Юнескогийн Гудамж, Нарны зам 62,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот, Монгол улс

2023 .03. 28

Огноо: _____

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Тодруулга	2022	2021 Дахин тайлагнасан*
Үр ашигт хүүний аргаар тооцсон хүүний орлого	5	81,901,202	49,559,320
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	5	3,220,930	1,255,420
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(45,956,759)	(24,881,973)
Хүүний цэвэр орлого		39,165,373	25,932,767
Хураамж ба шимтгэлийн орлого	6	1,205,971	376,799
Хураамж ба шимтгэлийн зардал	6	(1,150,338)	(462,092)
Хураамж ба шимтгэлийн цэвэр зардал		55,633	(85,293)
Арилжааны цэвэр орлого	7	4,038,048	1,457,159
ААБҮЦ-ээр хэмжигдэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн бусад орлого (зардал)	8	(1,947,392)	(177,896)
Үйл ажиллагааны нийт орлого		41,311,662	27,126,737
Бусад орлого	9a	3,536,042	54,652
Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтын гарз	12	(9,299,839)	(589,482)
Хүний нөөцийн зардал	10	(10,414,223)	(5,443,150)
Элэгдэл ба хорогдуулга		(5,922,646)	(4,010,633)
Бусад зардал	9б	(5,172,801)	(3,071,270)
Үйл ажиллагааны бус зардал	11	(406,329)	(221,457)
Татварын өмнөх ашиг		13,631,866	13,845,397
Орлогын албан татварын зардал	13	(2,944,032)	(2,440,975)
Тайлант жилийн цэвэр ашиг		10,687,834	11,404,422
Бусад дэлгэрэнгүй орлого			
Тодорхой шалгуур хангасан тохиолдолд ашиг, алдагдал руу шилжих бусад дэлгэрэнгүй орлого:			
Бодит үнэ цэнийн нөөцийн хөдөлгөөн (БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх өрийн хэрэгсэл):			
- Бодит үнэ цэнээрх цэвэр өөрчлөлт		19,574	95,491
- Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан		(95,491)	(18,128)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		10,611,917	11,481,785

*СТОУС 9-ийн шаардлагын дагуу дахин тайлагнал хийсэн ба дэлгэрэнгүй тодруулгыг 2.(д)-аас харна уу.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Байдлын Тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

(Мянган төгрөгөөр)	Тодруулга	2022.12.31	2021.12.31 Дахин тайлагнасан*
Хөрөнгө			
Бэлэн ба Монголбанк дахь мөнгө	14	160,399,785	93,334,148
Монголбанк дахь заавал байлгах нөөц	14	70,409,793	29,413,446
Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	15	321,818,852	37,585,022
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	4,748,884	2,832,448
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	640,791	69,765,709
Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	6,889,076	10,348,243
Дериватив санхүүгийн хөрөнгө	17	3,813,582	35,712
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	556,700,648	433,651,455
Үндсэн хөрөнгө	19	5,768,529	6,544,526
Биет бус хөрөнгө	20	5,894,523	5,432,936
Ашиглах эрхтэй хөрөнгө	22	14,087,808	4,501,363
Хойшлогдсон татварын хөрөнгө	13	-	355,657
Бусад хөрөнгө	23	6,236,675	34,728,868
Гүүдвил	21	4,591,561	4,591,561
Нийт хөрөнгө		1,162,000,507	733,121,094
Эздийн өмч ба өр төлбөр			
Өр төлбөр			
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	24	374,088,532	90,063,973
Харилцагчдын харилцах, хадгаламж	25	525,090,994	318,303,255
Репоз хэлцэл	26	6,019,946	76,731,558
Зээлээр авсан санхүүжилт	27	40,696,557	47,066,560
Дериватив санхүүгийн өр төлбөр	17	5,839,782	20,009
Орлогын албан татварын өглөг	13	184,314	894,892
Хойшлогдсон татварын өглөг	13	178,300	-
Бусад өр төлбөр	28	23,679,289	17,399,985
Нийт өр төлбөр		975,777,714	550,480,232
Эздийн өмч			
Энгийн хувьцаа	30	139,442,306	146,473,811
Нэмж төлөгдсөн капитал	30	15,646,926	15,645,407
Бусад нөөцүүд	30	1,103,813	124,009
Хуримтлагдсан ашиг		30,029,748	20,397,635
Нийт эздийн өмч		186,222,793	182,640,862
Нийт эздийн өмч ба өр төлбөр		1,162,000,507	733,121,094

*СТОУС 9-ийн шаардлагын дагуу дахин тайлагнал хийсэн ба дэлгэрэнгүй тодруулгыг 2.(д)-аас харна уу.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
 Өмчийн Өөрчлөлтийн Тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	БҮЦ-ээрх нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2021 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	100,000,000	-	18,128	28,518	8,993,213	109,039,859
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	11,404,422	11,404,422
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>						
– Бодит үнэ цэнээрх цэвэр өөрчлөлт	-	-	95,491	-	-	95,491
– Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан	-	-	(18,128)	-	-	(18,128)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	77,363	-	11,404,422	11,481,785
Нэгдэлтэй холбоотойгоор нэмж гаргасан хувьцаа	46,473,811	15,645,407	-	-	-	62,119,218
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл (Дахин тайлагнасан*)	146,473,811	15,645,407	95,491	28,518	20,397,635	182,640,862
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	10,687,834	10,687,834
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>						
– Бодит үнэ цэнээрх цэвэр өөрчлөлт	-	-	19,574	-	-	19,574
– Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан	-	-	(95,491)	-	-	(95,491)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(75,917)	-	10,687,834	10,611,917
Буцаан худалдан авсан хувьцаа	(7,031,505)	-	-	-	-	(7,031,505)
Кредит банкны ЗМТ-д оруулсан хөрөнгө оруулалтын хүлээн зөвшөөрөлт	-	1,519	-	-	-	1,519
Тусгай зориулалтын нөөцөд шилжүүлсэн	-	-	-	1,056,292	(1,056,292)	-
Хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	(571)	571	-
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	139,442,306	15,646,926	19,574	1,084,239	30,029,748	186,222,793

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
 Өмчийн Өөрчлөлтийн Тайлан, үргэлжлэл
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	БҮЦ-ээрх нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2020 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	78,000,000	-	105,740	28,518	3,519,083	81,653,341
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	5,474,130	5,474,130
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>						
– Бодит үнэ цэнээрх цэвэр өөрчлөлт	-	-	18,128	-	-	18,128
– Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан	-	-	(105,740)	-	-	(105,740)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(87,612)	-	5,474,130	5,386,518
Нэмж оруулсан хөрөнгө оруулсан	22,000,000	-	-	-	-	22,000,000
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	100,000,000	-	18,128	28,518	8,993,213	109,039,859
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	11,404,422	11,404,422
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>						
– Бодит үнэ цэнээрх цэвэр өөрчлөлт	-	-	95,491	-	-	95,491
– Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан	-	-	(18,128)	-	-	(18,128)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	77,363	-	11,404,422	11,481,785
Нэгдэлтэй холбоотойгоор нэмж гаргасан хувьцаа	46,473,811	15,645,407	-	-	-	62,119,218
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл (Дахин тайлагнасан*)	146,473,811	15,645,407	95,491	28,518	20,397,635	182,640,862

*СТОУС 9-ийн шаардлагын дагуу дахин тайлагнал хийсэн ба дэлгэрэнгүй тодруулгыг 2.(д)-аас харна уу.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК

Мөнгөн Гүйлгээний Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Тодруул -га	2022	2021 Дахин тайлагнасан*
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн цэвэр ашиг		10,687,834	11,404,422
Тохируулгууд:			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	19	1,896,372	1,299,011
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	22	3,463,883	2,394,595
Биет бус хөрөнгийн хорогдуулга	20	562,391	317,027
Данснаас хассан үндсэн хөрөнгө (ашиглах эрхтэй хөрөнгөөс бусад)	96, 19	108,676	107,371
Цуцалсан түрээсийн нөлөөлөл	96, 22	1,058	-
Хүүний цэвэр орлого	5	(39,165,373)	(25,932,767)
Үнэ цэнийн бууралтын гарз, цэвэр	12	9,299,839	589,482
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх харилцагчид олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын гарз (буцаалт)	8	(127,909)	150,382
Орлогын албан татварын зардал	13	2,944,032	2,440,975
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Монголбанкинд заавал байлгах нөөц	29	(40,996,347)	(21,623,548)
Бусад банкинд байршуулсан хязгаарлалттай мөнгөн хөрөнгө	29	-	(4,381,454)
Дериватив санхүүгийн хөрөнгө	17	(5,390,309)	(566,110)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	(114,059,064)	(83,326,243)
Бусад хөрөнгө	23	29,848,128	242,999
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	24	279,810,405	(62,866,330)
Харилцагчдын харилцах, хадгаламж	25	173,293,381	179,910,628
Репо хэлцэл	26	(69,226,166)	41,620,904
Дериватив санхүүгийн өр төлбөр	17	7,451,081	557,278
Бусад өр төлбөр	28	(3,931,610)	1,936,211
Хүлээн авсан хүү		78,483,941	45,595,920
Төлсөн хүү		(42,711,987)	(19,646,134)
Түрээсийн өр төлбөрт төлсөн хүү	22	(942,274)	(694,188)
Төлсөн орлогын албан татвар		(2,225,425)	(2,572,347)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		279,074,557	66,958,084

Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас харна уу.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК

Мөнгөн Гүйлгээний Тайлан, үргэлжлэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тодруул -га</i>	2022	2021 Дахин тайлагнасан*
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Нэгдлийн үр дүнд хүлээн авсан мөнгөн хөрөнгө		-	10,194,984
Худалдан авсан үндсэн хөрөнгө	19	(2,101,779)	(5,838,653)
Үндсэн хөрөнгийн борлуулалт	19	872,728	655,545
Худалдан авсан биет бус хөрөнгө	21	(1,023,978)	(186,613)
Худалдан авсан БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх үнэт цаас	16	(355,851,000)	(579,611,716)
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх үнэт цаасны төлөлт	16	425,134,000	532,776,320
Худалдан авсан ХӨ-өөр илэрхийлэх үнэт цаас	16	(3,500,000)	(10,085,500)
ХӨ-өөр илэрхийлэгдэх үнэт цаасны төлөлт	16	5,509,600	-
Худалдан авсан ААБҮЦ-ээр илэрхийлэх үнэт цаас	16	(2,482,000)	(3,540,200)
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх үнэт цаасны төлөлт	16	2,002,200	961,267
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		68,559,771	(54,674,566)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлээр авсан санхүүжилт	27	32,132,952	27,063,352
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт	27	(43,783,558)	(10,576,535)
Халаасны хувьцаа буцаан худалдан авалт	30	(7,031,505)	-
Төлсөн түрээсийн өр төлбөр	22	(4,175,281)	(2,301,058)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(22,857,392)	14,185,759
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өөрчлөлт			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		324,776,936	26,469,277
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29	126,537,716	100,752,254
Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөө		30,903,985	(683,815)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29	482,218,637	126,537,716

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

1. Тайлагнагч аж ахуйн нэгж

Тээвэр Хөгжлийн Банк ХК (цаашид “Банк” гэх) нь Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, тус улсад үйл ажиллагаа эрхэлдэг хаалттай Хувьцаат компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж, Шангри-Ла оффис, 15 дугаар давхар.

Банкны тухай Монгол улсын хуулийг үндэслэн Монголбанкнаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Тээвэр хөгжлийн банкнийг “хязгаарлагдмал хариуцлагатай компани” (ХХК)-аас “хаалттай хувьцаат компани” (ХК) болгон өөрчлөн байгуулах зөвшөөрлийг олгосон.

2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Банк нь ХХК-аас “хаалттай ХК” болж өөрчлөгдөн байгуулагдсаныг Улсын бүртгэлийн газарт бүртгэсэн.

Банк нь Банкны тухай хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 1997 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн тушаалаар банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 1997 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр 2078201 тоот регистрийн дугаар бүхий гэрчилгээ авч, арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх 12 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан.

Банк нь Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд нийцүүлэн Монголбанкнаас 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гаргасан зөвшөөрлийн дагуу 2021 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Кредит банк ХХК-тай албан ёсоор нэгдсэн. Нэгдэл нь Банк болон Кредит банк хооронд байгуулсан Хуулийн этгээдийн нэгдэх/нэгтгэх гэрээгээр зохицуулагдсан ба 2021 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Кредит банкны бүх хөрөнгө, өр төлбөр, нөөц болон салбарууд нь Банкинд нэгтгэгдсэн.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Банкнийг зургаан хувь хүн, нэг компани эзэмшдэг ба эцсийн хяналт тавигч этгээд нь П.Раднаабазар байсан.

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

(а) Мөрдсөн стандарт

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан.

Банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Банкны Захирлууд батламжилсан.

(б) Хэмжилтийн үндэслэл

Санхүүгийн тайланг холбогдох тодруулгад тусгайлан тодруулснаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(в) Бүртгэлийн ба тайлагналын валют

Энэхүү санхүүгийн тайланг Банкны бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг (MNT)-өөр толилуулсан бөгөөд энэ нь Банкны үйл ажиллагаа явуулж буй гол эдийн засгийн орчны үндсэн валют болно. Тусгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар санхүүгийн тайланг мянгачилж толилуулсан.

(г) Тооцоолол болон шийдлийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон шийдэл хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, шийдэл нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Тооцооллыг хийхэд өнөөгийн болон хүлээгдэж буй эдийн засгийн нөхцөл байдал, түүхэн туршлага гэх мэт хүчин зүйлс, мөн олон төрлийн таамаглал дээр суурилсан шийдэл гаргахыг шаарддаг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр таамаглал, тооцоололоос ялгаатай байж болно.

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл, үргэлжлэл

(г) Тооцоолол болон шийдлийн хэрэглээ, үргэлжлэл

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөллийг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

(i) Шийдэл

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдсэн шийдлийн талаарх мэдээллийг доорх тодруулгуудад тусгасан:

- Тодруулга 35 (2): анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлох шалгуурыг тогтоох, хүлээгдэж байгаа зээлийн алдагдлын хэмжилтэд ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашиглах аргачлалыг тодорхойлох, хүлээгдэж байгаа зээлийн алдагдлыг хэмжихэд ашиглагдах загварыг сонгон батлах.
- Тодруулга 4 (б)(ii): санхүүгийн хөрөнгийн ангилал: тухайн хөрөнгийг удирдаж буй байгууллагын бизнес загварын үнэлгээ, үлдэх үндсэн төлбөрийн дүн зөвхөн үндсэн болон хүүний төлбөр эсэхийг санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлөөр үнэлэх.
- Тодруулга 4 (м)(i): түрээсийн хугацаа: Банк түрээсийн хугацааны сунгалттай холбоотой сонголтыг үндэслэлтэйгээр тодорхойлж, ашигласан эсэх.

(ii) Таамаглал болон тооцооллын тодорхойгүй байдал

Дараагийн санхүүгийн жилд материаллаг залруулгад хүргэж болох нөлөөлөхүйц эрсдэлтэй тооцоолол болон таамаглалын тодорхойгүй байдлын талаарх мэдээлэл дараах тодруулгуудад орсон болно.

- Санхүүгийн хөрөнгийн ангилал – Тодруулга 4 (б)(ii);
- Санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралт – Тодруулга 4 (б)(vi)
- Гүүдвیلیйн үнэ цэнийн бууралт- Тодруулга 21

(iii) Бодит үнэ цэнийн хэмжилт

Банк нь хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тухайн зах зээл дээрх хамгийн сайн ажиглагдахуйц мэдээллийг ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ашиглагдах өгөгдлүүдээс нь хамааруулан дараах шатлалаар ангилдаг:

- Түвшин 1: ижил төстэй хөрөнгө эсвэл өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ
- Түвшин 2: тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд 1 дүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад өгөгдлүүд, шууд (ж.нь үнэ) эсвэл шууд бусаар (ж.нь үнээс хамааралтай)
- Түвшин 3: хөрөнгө эсвэл өр төлбөрийн зах зээлийн ажиглагдахуйц мэдээлэл дээр суурилагүй өгөгдлүүд

Хэрэв хөрөнгө эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход бодит үнэ цэнийн ялгаатай шатлалууд дамжсан мэдээллүүдийг ашигласан бол Банк нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход гол нөлөөлсөн өгөгдлийн бодит үнэ цэнийн шатлалын хамгийн доод түвшнээр тодорхойлох ба бодит цэнийн үнэлгээний шатлалын хооронд шилжилт гарсан тохиолдолд тайлант үеийн эцэст эдгээр шилжилтүүдийг хүлээн зөвшөөрдөг.

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл, үргэлжлэл

(г) Тооцоолол болон шийдлийн хэрэглээ, үргэлжлэл

(iv) Тасралтгүй байх зарчим

Санхүүгийн тайланг удирдлага зохистой гэж үзсэний дагуу тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

(д) Өмнөх тайлант жилийн дахин тайлагнал

Банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланг бэлтгэх явцад тухайн тайлант хугацаанд дараах нягтлан бодох бүртгэлийн аргачлалын зөрүүтэй байдлыг тодорхойлж, өмнөх жилийн санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийж дахин тайлагнасан:

- (i) Банк нь өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бизнес загвар болон гэрээний мөнгөн үрсгалын шинж чанарыг тодорхойлохдоо зарим зүйлсийг өөр аргачлалаар авч үзсэнээс хөрөнгө оруулалтын ангиллыг зөрүүтэй тодорхойлсон байсан. СТОУС 9-ийн дагуу эдгээр хөрөнгө оруулалтын ангиллыг залруулж тохируулсан. Ангилал залруулсантай холбоотой хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй алдагдлыг дахин тооцоолж, ашиг (алдагдал) болон бусад дэлгэрэнгүй орлого хооронд залруулав.
- (ii) 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Засгийн Газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Хөтөлбөр 5 хэсгээс бүрдэх бөгөөд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр 2021 оны 3 дугаар сард эхэлсэн. Энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд жилийн 10.5 хувийн хүүтэй, 2-с 3 жилийн хугацаатай, 10,045 сая төгрөгийн жижиг дунд бизнесийг дэмжих зээлийн багцийг Үнэт Цаас Санхүүжилтийн Корпораци (ҮЦСК)-д худалдаж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас хүлээн авсан. Банк нь ҮЦСК-д худалдсан зээлийг 2021 оны санхүүгийн тайланд үл хүлээн зөвшөөрч толилуулсан байсан.
Банк ҮЦСК-д худалдсан эдгээр зээлийн бараг бүх эрсдэлийг өөртөө үлдээсэн байх тул энэ нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцэхгүй байна. Тиймээс, үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцээгүй хөрөнгө болон зээл худалдахтай холбоотой хүлээн авсан төлбөрийг санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч тус тус дахин тайлагнав. Дахин тайлагнасан санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг мөн дахин тооцоолж санхүүгийн тайланд тусгасан.
- (iii) Худалдан борлуулах бизнес загвар бүхий харилцагчид олгосон зээлийг “хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө” гэж ангилсныг ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэгслээр ангилж дахин тайлагнасан.

Дээрх өөрчлөлтүүдтэй холбогдох тохируулга дараах байдлаар тайланд тусгагдсан:

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл, үргэлжлэл

(д) Өмнөх тайлант жилийн дахин тайлагнал, үргэлжлэл

Санхүүгийн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)	Тайлбар	2021.12.31 Аудитлагдсан	Залруулга	2021.12.31 Дахин тайлагнасан
Хөрөнгө				
Бэлэн ба Монголбанк дахь мөнгө		93,334,148	-	93,334,148
Монголбанк дахь заавал байлгах нөөц		29,413,446	-	29,413,446
Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		37,585,022	-	37,585,022
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	(i)	13,217	2,819,231	2,832,448
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	(i)	80,520,228	(10,754,519)	69,765,709
Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	(i)	2,427,215	7,921,028	10,348,243
Дериватив санхүүгийн хөрөнгө		35,712	-	35,712
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(ii), (iii)	423,569,662	10,081,793	433,651,455
Үндсэн хөрөнгө		6,544,526	-	6,544,526
Биет бус хөрөнгө		5,432,936	-	5,432,936
Ашиглах эрхтэй хөрөнгө		4,501,363	-	4,501,363
Хойшлогдсон татварын хөрөнгө		355,657	-	355,657
Бусад хөрөнгө		34,728,868	-	34,728,868
Гүүдвил		4,591,561	-	4,591,561
Нийт хөрөнгө		723,053,561	10,067,533	733,121,094
Эздийн өмч ба өр төлбөр				
Өр төлбөр				
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		90,063,973	-	90,063,973
Харилцагчдын харилцах, хадгаламж		318,303,255	-	318,303,255
Репо хэлцэл		76,731,558	-	76,731,558
Зээлээр авсан санхүүжилт		47,066,560	-	47,066,560
Дериватив санхүүгийн өр төлбөр		20,009	-	20,009
Орлогын албан татварын өглөг		894,892	-	894,892
Хойшлогдсон татварын өглөг		-	-	-
Бусад өр төлбөр	(ii)	7,270,068	10,129,917	17,399,985
Нийт өр төлбөр		540,350,315	10,129,917	550,480,232
Эздийн өмч				
Энгийн хувьцаа		146,473,811	-	146,473,811
Нэмж төлөгдсөн капитал		15,645,407	-	15,645,407
Бусад нөөцүүд	(i)	138,269	(14,260)	124,009
Хуримтлагдсан ашиг	(i),(ii),(iii)	20,445,759	(48,124)	20,397,635
Нийт эздийн өмч		182,703,246	(62,384)	182,640,862
Нийт өр төлбөр ба эздийн өмч		723,053,561	10,067,533	733,121,094

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл, үргэлжлэл

(д) Өмнөх тайлант жилийн дахин тайлагнал, үргэлжлэл

Ашиг, Алдагдал болон Бусад Орлогын Дэлгэрэнгүй Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Тайлбар	2021.12.31 Аудитлагдсан	Залруулга	2021.12.31 Дахин тайлагнасан
Хүү болон түүнтэй адилтгах орлого		50,814,740	-	50,814,740
Хүү болон түүнтэй адилтгах зардал		(24,881,973)	-	(24,881,973)
Хүүний цэвэр орлого		25,932,767	-	25,932,767
Хураамж ба шимтгэлийн орлого		376,799	-	376,799
Хураамж ба шимтгэлийн зардал		(462,092)	-	(462,092)
Хураамж ба шимтгэлийн цэвэр зардал		(85,293)	-	(85,293)
Арилжааны цэвэр орлого		1,457,159	-	1,457,159
ААБҮЦ-ээр хэмжигдэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн бусад орлого (зардал)	(iii)	(27,514)	(150,382)	(177,896)
Үйл ажиллагааны нийт орлого		27,277,119	(150,382)	27,126,737
Бусад орлого		54,652	-	54,652
Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтын гарз	(i),(ii),(iii)	(691,740)	102,258	(589,482)
Хүний нөөцийн зардал		(5,443,150)	-	(5,443,150)
Элэгдэл ба хорогдуулга		(4,010,633)	-	(4,010,633)
Бусад зардал		(3,071,270)	-	(3,071,270)
Үйл ажиллагааны бус зардал		(221,457)	-	(221,457)
Татварын өмнөх ашиг		13,893,521	(48,124)	13,845,397
Орлогын албан татварын зардал		(2,440,975)	-	(2,440,975)
Тайлант жилийн цэвэр ашиг		11,452,546	(48,124)	11,404,422
Бусад дэлгэрэнгүй орлого				
Тодорхой шалгуур хангасан тохиолдолд ашиг, алдагдал руу шилжих бусад дэлгэрэнгүй орлого:				
Бодит үнэ цэнийн нөөцийн хөдөлгөөн (БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх өрийн хэрэгсэл):				
- Бодит үнэ цэнээрх цэвэр өөрчлөлт	(i)	109,751	(14,260)	95,491
- Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан		(18,128)	-	(18,128)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		11,544,169	(62,384)	11,481,785

3. Шинэ ба шинэчлэгдсэн стандартууд, тайлбарууд

(а) 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

2022 оны 01-р сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн нэмэлт өөрчлөлтүүд:

- Давагдашгүй гэрээ – Гэрээ биелүүлэх зардал (НББОУС 37-ын нэмэлт өөрчлөлт);
- Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого (НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлт);
- 2018-2020 оны стандартуудын сайжруулалт (СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 болон НББОУС 41-ийн нэмэлт өөрчлөлт); болон
- Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж (СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт).

Дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь Банкинд материаллаг нөлөө үзүүлээгүй.

(б) Тайлант жилд мөрдөгдөж эхлээгүй байгаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс шинээр гаргасан стандартууд

Банкны санхүүгийн тайланг батламжилан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа НББОУСЗ-өөс гаргасан стандартууд болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдийг Банк эрт хэрэгжүүлэхээр шийдвэрлээгүй.

2023 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх нэмэлт өөрчлөлтүүд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга (НББОУС 1 болон СТОУС практикийн бичиг баримт 2-ын нэмэлт өөрчлөлт);
- Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт (НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт);
- Нэг ажил гүйлгээнээс үүсч буй хөрөнгө ба өр төлбөрийн хойшлогдсон татвар (НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт); болон
- СТОУС 17 Даатгалын гэрээ (2023 оны 01 сарын 01-нээс хэрэгжих) – 2020 оны 6 сард НББОУСЗ-өөс СТОУС 17-ын нэмэлт өөрчлөлтийг гаргасан ба хэрэгжиж эхлэх хугацааг 2023 оны 01 сарын 01 хүртэл хойшлуулсан.

2024 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхлэх нэмэлт өөрчлөлтүүд:

- СТОУС 16 Түрээс (Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгийн түрээсийн өр төлбөртэй холбоотой нэмэлт өөрчлөлт);
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга (Богино хугацаат болон үрт хугацаат өр төлбөрийн ангилалтай холбоотой нэмэлт өөрчлөлт); болон
- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга (Гэрээтэй богино хугацаат өр төлбөртэй холбоотой нэмэлт өөрчлөлт).

Банк одоогоор эдгээр нэмэлт өөрчлөлтийн нөлөөллийг үнэлж байна.

Стандартын нэмэлт өөрчлөлтүүд болон тайлбар тодруулгууд нь Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Банк санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах бодлогуудыг баримталсан ба эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь тайланд тусгагдсан бүх жилүүдэд тогтвортойгоор хэрэглэгдсэн болно.

(а) Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Мөнгөн зүйлсийн ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарз нь тайлант жилийн эхэнд бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн хорогдуулсан өртөг, тухайн тайлант жилийн үр ашигт хүү, үнэ цэнийн бууралт болон төлбөрийн тохируулга, тайлант жилийн эцэс дэх бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн хорогдуулсан өртгийн зөрүү байдаг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

Ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг тухайн тайлант жилийн ашиг, алдагдлаар зөвшөөрч тайлагнадаг. Харин дараах ажил гүйлгээтэй холбоотой ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг:

- бодит үнэ цэнийн дараагийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тайлагнах зорилгоор сонгосон өмчийн хөрөнгө оруулалтын өөрчлөлт;
- хэйджийг үр дүнтэй байгаа тохиолдолд гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтыг хэйдж болгон тодорхойлсон санхүүгийн өр төлбөр; ба
- хэйджийг үр дүнтэй байх нөхцөлийн мөнгөн урсгал.

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр

(i) Хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилт

Банк зээл ба урьдчилгаа, хадгаламж, гаргасан өрийн үнэт цаас, хоёрдогч өр төлбөр зэргийг үүссэн өдрөөр нь анх хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хэрэгслүүд (санхүүгийн хөрөнгийн тогтмол худалдан авалт, борлуулалтыг хамруулаад)-ийг Банк гэрээний дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон үеэс буюу арилжаа хийгдэх үед хүлээн зөвшөөрнө.

ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй зүйлсийн хувьд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг эдгээрийг худалдан авах, гаргахтай холбоотой гарсан шууд хамааралтай зардлыг бодит үнэ цэн дээр нэмж анх хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэн нь ихэвчлэн ажил гүйлгээний үнэтэйгээ ижил байдаг.

(ii) Ангилал

Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлтөөр санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр, БДОБҮЦ эсвэл ААБҮЦ-ээр хэмжигдэнэ. Санхүүгийн хөрөнгө нь дараах шалгуурыг хангасан ба ААБҮЦ-ээр хэмжигддэг биш бол хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- хөрөнгийг гэрээт мөнгөн урсгал цуглуулах зорилгоор эзэмшдэг бизнесийн загвартай; болон
- гэрээний нөхцөл нь үндсэн төлбөр дээр бодогддог хүү болон үндсэн төлбөрийн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх өдрүүдэд нөлөө үзүүлдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(ii) Ангилал, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө нь дараах шалгуурыг хангасан ба ААБҮЦ-ээр хэмжигддэг биш бол БДОБҮЦ-ээр хэмжигдэнэ:

- хөрөнгийг гэрээт мөнгөн үрсгал цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмшдэг бизнес загвартай; мөн
- гэрээний заалт нь үндсэн төлбөр дээр бодогддог хүүний болон үндсэн төлбөрийн төлөлтийн мөнгөн үрсгал орж ирэх өдрүүдэд нөлөө үзүүлдэг.

Борлуулах зорилгоор эзэмшээгүй өмчийн хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн үед Банк нь эргэлт буцалтгүйгээр хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэд гарах дараа үеийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх сонголт хийж болно. Энэхүү сонголтыг хөрөнгө оруулалт тус бүрт хийж болно.

Бусад бүх санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр хэмжигдэнэ.

Үүнээс гадна, БДОБҮЦ эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжигдэх шалгуурыг хангасан санхүүгийн хөрөнгийг тийнхүү үнэлснээс үүдэн гарах нягтлан бодох бүртгэлийн үл нийцлийг арилгах буюу мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах тохиолдолд эргэлт буцалтгүйгээр анхны хүлээн зөвшөөрөлтөнд ААБҮЦ-ээр ангилж болно.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед Банк нь санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртөг эсвэл БДОБҮЦ-ээр хэмжигдэх шаардлагыг хангахаас бусад үед энэхүү санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмжигдэнэ гэж тодорхойлох нь нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах тохиолдолд эргэлт буцалтгүйгээр уг ангилалд оруулж болно.

Бизнес загварын үнэлгээ

Банк бизнесийн үйл ажиллагааны удирдлага болон удирдлагад мэдээлэл толилуулах хэлбэрийг хамгийн зохистойгоор илэрхийлдэг хэмээн үздэг тул багц хэлбэрээр хөрөнгө эзэмших бизнес загварын зорилтын үнэлгээг хийдэг.

Харгалзаж үзсэн мэдээлэлд дараах зүйлс хамаарна:

- багцын бодлого болон зорилтууд, мөн бодлогын практик дээрх хэрэгжилт. Үүнд, удирдлагын стратеги нь гэрээгээрх хүүний орлогыг цуглуулах, тодорхой хүүний түвшинг хэмжээнд нь барих, санхүүгийн хөрөнгийн үргэлжлэх хугацааг холбогдох өр төлбөр эсвэл хүлээгдэж буй гадагшаа мөнгөн үрсгалтай нь уялдуулах эсвэл хөрөнгийг борлуулан мөнгөн үрсгал бий болгох зэргийн алинд анхаарч байгаа нь хамаарна;
- хэрхэн багцын гүйцэтгэлийг үнэлж, Банкны удирдлагад тайлагнадаг талаар;
- бизнес загварын гүйцэтгэлд нөлөөлдөг эрсдэлүүд (ба энэхүү бизнес загварт хамаарах санхүүгийн хөрөнгүүд) болон хэрхэн энэ эрсдэлүүдийг удирддаг талаар;
- бизнесийн менежерүүд хэрхэн цалинждаг талаар – жишээ нь: цалин нь удирдагдаж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээгээрх мөнгөн үрсгалын цуглуулсан хэмжээн дээр суурилсан эсэх; ба
- өмнөх үеийн санхүүгийн хөрөнгийн борлуулалтын давтамж, хэмжээ болон цаг хугацаа, энэхүү борлуулалтуудын шалтгаан болон ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны талаарх хүлээлт. Борлуулалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг дангаар нь авч үздэггүй боловч Банк санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдан мөнгөн үрсгалыг бий болгох зорилгын нийт үнэлгээний хүрээний нэг хэсэгт авч үздэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(ii) Ангилал, үргэлжлэл

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл тухайн зорилгоор удирдагддаг ба гүйцэтгэл нь бодит үнэ цэнийн сууриар үнэлэгддэг санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр хэмжигдэнэ. Учир нь санхүүгийн хөрөнгийг гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах эсвэл гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмшээгүй болно.

Гэрээт мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүний төлбөрөөс бүрддэг эсэх үнэлгээ

Энэхүү үнэлгээний зорилгоор “үндсэн төлбөр” гэдгийг санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэн гэж ойлгоно. “Хүү” гэдэгт мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөр ба тодорхой цаг хугацааны үндсэн төлбөрийн зээлийн эрсдэлийн төлбөр ба бусад энгийн зээллэгийн эрсдэл болон өртөг, мөн дээр нь ашгийн хэмжээ зэрэг орно.

Гэрээгээрх мөнгөн урсгал нь гагцхүү үндсэн болон хүүний төлбөрөөс бүрддэг эсэхийг үнэлэхдээ, Банк нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээгээрх заалтуудыг харгалзан үздэг. Үүнд, санхүүгийн хөрөнгө нь шаардлага хангах эсэхэд нөлөөлөхгүйц гэрээгээрх мөнгөн урсгалын орж ирэх хугацаа эсвэл дүнг өөрчилж болох гэрээний нөхцөл агуулсан эсэхийг үнэлэх хамаарна. Энэхүү үнэлгээг хийхдээ, Банк нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- мөнгөн урсгалын хугацаа болон дүнг өөрчлөх болзошгүй үйл явдлууд;
- хөшүүргийн онцлог;
- урьдчилж төлөх болон сунгах шинж чанарууд;
- тодорхой хөрөнгүүдээс Банк мөнгөн урсгал шаардах явдлыг хязгаарлах заалтууд; ба
- мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзах шинж чанарууд – жишээ нь: Тогтмол хугацаанд хүүний түвшинг дахин тохируулах.

Дахин ангилал

Банк санхүүгийн хөрөнгө удирдах бизнес загвартаа өөрчлөлт оруулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгө нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа дахин ангилагдахгүй.

Санхүүгийн өр төлбөр

Банк нь санхүүгийн баталгаа болон зээлийн үүргүүдээс бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг.

(iii) Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгө

Банк нь тухайн санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл тухайн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг эзэмших гэрээний эрхээ бусдад санхүүгийн хөрөнгийн бараг бүх өгөөж болон эрсдэлийн хамтаар шилжүүлсэн, эсвэл санхүүгийн хөрөнгийн бараг бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлээгүй боловч хадгалж үлдээгүй ба хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдээгүй бол санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хөрөнгийн дансны үнэ (эсвэл хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөгдөж буй хэсгийн дансны үнэ) болон (i) шинээр хүлээн авсан хөрөнгөөс шинээр тооцоолсон

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

өр төлбөрийг хассаны дараах хүлээн авсан төлбөр болон (ii) бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзын нийлбэрийн зөрүүгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(iii) Үл хүлээн зөвшөөрөлт, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

БДОБУЦ-ээр илэрхийлэгдэх өмчийн хөрөнгө оруулалтын үнэт цаасны бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн ашиг, алдагдал нь үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөхгүй. Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөх нөхцөлийг хангасан боловч Банк өөртөө хадгалсан хэсгийг тусдаа хөрөнгө эсвэл өр төлбөрөөр бүртгэнэ.

Банк нь санхүүгийн байдлын тайланд тусгасан байсан хөрөнгийг бусдад шилжүүлсэн боловч тэдгээр хөрөнгийн эсвэл тодорхой хэсгийнх нь бүх эсвэл бараг бүх эрсдэл, өгөөжийг хадгалсан хэвээр үлдэх хэлцэл хийх тохиолдол байдаг. Ийм тохиолдолд, шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Ийм ажил гүйлгээний жишээ нь үнэт цаасны зээл, борлуулалт болон буцаан худалдан авах ажил гүйлгээ зэрэг юм.

Банк нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлээгүй болон өөртөө хадгалаагүй боловч хөрөнгөд хяналт тавих эрхийг хадгалж үлдсэн бол Банк нь уг хөрөнгийг өөрийн оролцооны хэр хэмжээгээр өөрөөр хэлбэл шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөнд хэдий хэмжээгээр өртсөн хэвээр байгаа тэр хувь хэмжээгээр нь бүртгэлдээ хэвээр үлдээнэ.

Банк хөрөнгийг бүхлээр нь бус хэсгийг нь шилжүүлэх буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгө бүхий банкинд бүхэлд нь шилжүүлж байгаа үед хэрэглэж болохоор бол үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг мөн ашигладаг. Хэрвээ хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлж байгаа бол энэхүү хэсэг нь тодорхойлон тооцоолох боломжтой мөнгөн урсгал, хөрөнгийн бүрэн хуваарилагдсан хэсэг буюу тодорхойлон тооцох боломжтой мөнгөн урсгалын хэсэг байх шаардлагатай.

Санхүүгийн өр төлбөр

Банк санхүүгийн өр төлбөрийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрдөг.

(iv) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт

Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд Банк нь өөрчлөгдсөн хөрөнгийн мөнгөн урсгал эрс өөрчлөгдсөн эсэхийг үнэлдэг.

Хэрэв мөнгөн урсгал эрс өөрчлөгдсөн бол (томоохон өөрчлөлт хийгдсэн гэж үзвэл), гэрээний эрхийн дагуу анхны санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалын хугацааг дууссан гэж үзнэ. Энэхүү тохиолдолд, анхны санхүүгийн хөрөнгийг данснаас хасаж, шинэ санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэн дээр ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Өөрчлөлтийн хүрээнд хүлээн авсан аливаа шимтгэлийг дараах байдлаар бүртгэнэ:

- Шинэ санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход харгалзан үзсэн төлбөр болон ажил гүйлгээний зардал нь хөрөнгийн анхны хэмжилтэнд хамаарах; ба
- Бусад төлбөрийг үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарз хэмээн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс үүдэлтэй мөнгөн урсгалын өөрчлөлтийн зорилго нь эрс өөрчлөгдсөн нөхцөлтэй шинэ хөрөнгийг бий болгохоос илүүтэйгээр анхны хөрөнгийн гэрээний нөхцөлийн дагуу төлбөрийг нөхөх боломжийг ихэсгэхэд оршино.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(iv) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

Банк мөнгөн урсгалыг зөөллөх замаар санхүүгийн хөрөнгийг өөрчлөх төлөвлөгөөтэй байгаа бол үг өөрчлөлтийг хийхээс өмнө хөрөнгийг хэсэгчлэн данснаас хасах эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй (данснаас хасах бодлогыг доорх тодруулгаас харна үү). Энэ арга барил нь тоон үнэлгээний үр дүнд нөлөөлснөөр үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг ихэнхдээ хангадаггүй нөхцөл байдлыг бий болгодог.

Хорогдуулсан өртөг эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй тул Банк нь хөрөнгийн анхны үр ашигт хүүний түвшнийг ашиглан санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолж ашиг, алдагдлын тайлан дээр өөрчлөлтийн олз, гарз гэж тохируулна.

Хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгүүдийн хувьд өөрчлөлтийн үеийн зах зээлийн нөхцөлийг тусгахын тулд анхны үр ашигт хүүний түвшинг тохируулж олз, гарзыг залруулахдаа ашигладаг. Өөрчлөлтийн нэг хэсэг болж гарсан зардал, шимтгэл, мөн хүлээн авсан шимтгэл нь өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн дансны үнийг тохируулдаг ба үүнийг өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн үлдсэн хугацаанд хорогдуулдаг.

Хэрэв энэхүү өөрчлөлт нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс болж үүссэн бол олз болон гарз нь үнэ цэнийн бууралтын алдагдалтай хамт толилуулагдана. Бусад тохиолдлуудад үр ашигт хүүний аргаар тооцсон хүүний орлого хэсэгт толилуулна.

Санхүүгийн өр төлбөр

Банк нь санхүүгийн өр төлбөрийг нөхцөл нь өөрчлөгдсөн болон өөрчлөгдсөн төлбөрийн мөнгөн урсгал харилцан адилгүй байгаа тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд өөрчлөгдсөн нөхцөлд тулгуурласан шинэ санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хуучин санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ болон өөрчлөгдсөн нөхцөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн шинэ санхүүгийн өр төлбөрийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Төлсөн төлбөрт шилжүүлсэн санхүүгийн бус хөрөнгө (хэрэв байгаа бол), шинэчилсэн санхүүгийн өр төлбөрийг багтаасан төлбөрийн таамаглал зэрэг хамаарна.

Хэрэв санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөлт гэж бүртгээгүй бол анхны үр ашигт хүүний түвшинг ашиглан шинэчлэгдсэн мөнгөн урсгалыг дискаунтлан өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцоолж, үүссэн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хөвөгч хүүтэй санхүүгийн өр төлбөрийн хувьд өөрчлөлтийн үеийн зах зээлийн нөхцөлийг тусгахын тулд анхны үр ашигт хүүний түвшинг тохируулж олз, гарзыг залруулахдаа ашигладаг. Аливаа зардал ба шимтгэл нь өр төлбөрийн дансны үнийг залруулан хүлээн зөвшөөрөгддөг ба үүнийг өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн үлдсэн хугацаанд дахин тооцоолсон үр ашигт хүүний түвшнээр хорогдуулдаг.

(v) Цэвэр дүнгээр илэрхийлэх

Банк хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

Орлого ба зардлыг эсвэл Банкны арилжааны үйл ажиллагааны гэх мэт ижил төрлийн ажил гүйлгээнээс үүссэн олз, гарзыг СТОУС-ын дагуу хүлээн зөвшөөрсөн тохиолдолд цэврээр толилуулна.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(vi) Үнэ цэнийн бууралт

Банк хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэнээс бусад дараах санхүүгийн хэрэглүүрүүд дээр тооцдог:

- Өрийн хэрэглүүр болох санхүүгийн хөрөнгүүд;
- Санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт;
- Гаргасан санхүүгийн баталгаа болон гэрээ; мөн
- Гаргасан зээлийн үүргүүд.

Өмчийн хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрдөггүй.

Банк үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөцийг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжсэн дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн ашиглалтын хугацааны турших хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмждэг. Үүнд:

- Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөө үүсээгүй бусад санхүүгийн хэрэглүүрүүд (санхүүгийн түрээст оруулсан цэвэр хөрөнгө хөрөнгө оруулалтаас бусад).

Банк өрийн хөрөнгө оруулалтын үнэт цаасны зээлийн эрсдэлийн түвшин нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөх “Хөрөнгө оруулалтын зэрэглэл”-тэй нийцэж байвал бага зээлийн эрсдэлтэй гэж үздэг. Банк нь өөр бусад санхүүгийн хэрэглүүрүүдэд зээлийн эрсдэл бага байх нөхцөлийг авч үздэггүй.

12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал гэдэг нь тайлагналын өдрийн дараах 12 сарын хугацааны туршид дефолт болох боломжит үйл явдлуудын хүлээгдэж буй алдагдлын хувийг илэрхийлнэ. 12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалтай санхүүгийн хэрэглүүрүүд 1 дүгээр шатлалын санхүүгийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрөгддөг.

Ашиглалтын хугацааны турших хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны турших дефолт болох бүх боломжит үеүдийн үр дүнгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг хэлнэ. Ашиглалтын хугацааны турших хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалтай санхүүгийн хэрэглүүрүүд 2 дугаар шатлалын санхүүгийн хэрэглүүр (хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн, гэхдээ санхүүгийн хөрөнгөд үнэ цэнийн бууралт үүсээгүй) ба 3 дугаар шатлалын санхүүгийн хэрэглүүр (хэрэв санхүүгийн хэрэглүүрт үнэ цэнийн бууралт үүссэн бол) гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал гэдэг нь зээлийн алдагдлын хүлээгдэж буй жигнэсэн боломжит үнэлгээ юм. Энэ нь дараах байдлаар хэмжигдэнэ:

- *тайлагналын өдрөөр үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хөрөнгүүд*: бүх мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнэ (жишээ нь: гэрээний дагуух байгууллагын мөнгөн үрсгал болон Банкны авахаар хүлээгдэж буй мөнгөн үрсгалын зөрүү);
- *тайлагналын өдрөөр үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд*: дансны нийт үнэ болон ирээдүйн мөнгөн үрсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүү;
- *олгогдоогүй шугамын зээлийн үүргүүд*: хэрэв үүргээ цуцалсан бол Банкнд өгөх гэрээний мөнгөн үрсгал болон Банк хүлээн авах мөнгөн үрсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүү; болон
- *санхүүгийн баталгааны гэрээнүүд*: эзэмшигчид нөхөн олговор олгохоор хүлээгдэж буй төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс Банкны хүлээгдэж буй нөхөн авах дүнг хассан дүн.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(vi) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

Бүтцийн өөрчлөлтөд орсон санхүүгийн хөрөнгүүд

Хэрэв санхүүгийн хөрөнгийн нөхцөлүүд дахин хэлэлцэгдсэн эсвэл өөрчлөгдсөн эсвэл зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс үүдэн шинэчлэгдсэн бол санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дараах байдлаар тооцоолно.

- Хэрэв хүлээгдэж буй бүтцийн өөрчлөлт нь одоогийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөлтөд хүргэхгүй бол өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн үрсгал нь одоогийн хөрөнгийн мөнгөний дутагдлын тооцоололд орсон байна.
- Хэрэв хүлээгдэж буй бүтцийн өөрчлөлт нь одоогийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэх бол үл хүлээн зөвшөөрөхдөө шинэ хөрөнгийн хүлээгдэж буй бодит үнэ цэнийг одоогийн хөрөнгийн хамгийн сүүлчийн мөнгөн үрсгал хэмээн үзнэ. Энэ дүн нь одоогийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний түвшнээр үл хүлээн зөвшөөрөлтийн хүлээгдэж буй өдрөөр дискаунтлагдсан одоогийн санхүүгийн хөрөнгийн мөнгөний дутагдлын тооцоололд орсон дүн юм.

Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд

Банк нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн санхүүгийн хөрөнгүүд, мөн санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэн нь буурсан эсэхийг тайлант үе бүрт үнэлдэг. Санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн үрсгалын тооцоололд сөргөөр нөлөөлөх нэг буюу түүнээс олон үйл явдал гарсан тохиолдолд үнэ цэнэ нь буурсан гэж үзнэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан нотолгоонд дараах ажиглагдахуйц тоо баримтууд хамаарна:

- Зээлдэгчийн санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлтэй байдал;
- Гэрээний хугацаа хэтрэлттэй эсвэл дефолт болсон зэрэг гэрээний зөрчил;
- Банкны авч хэлэлцэхээргүй нөхцөлөөр зээл ба урьдчилгаанд Банк бүтцийн өөрчлөлт оруулах;
- Зээлдэгч нь дампуурах эсвэл түүнд санхүүгийн бүтцийн өөрчлөлт орох магадлалтай байх; эсвэл
- Санхүүгийн хүндрэлээс болж үнэт цаасыг арилжих идэвхтэй зах зээл байхгүй болох.

Хэрэв гэрээний мөнгөн дүнг авахгүй байх эрсдэл эрс буурсан баримт байгаа ба өөр үнэ цэнэ буурах үзүүлэлт байхгүй гэж үзээгүй л бол зээлдэгчийн нөхцөл байдалд хүндрэл гарсантай холбоотойгоор дахин хэлцэл хийсэн зээлийг үнэ цэнэ буурсан гэж үздэг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг санхүүгийн байдлын тайланд толилуулах нь

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нөөцийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар толилуулна:

- *хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүд*: хөрөнгийн дансны үнээс хасна;
- *зээлийн үүргүүд ба санхүүгийн баталгааны гэрээ*: ерөнхийдөө нөөцөөр толилуулна;
- *санхүүгийн хэрэглүүр нь олгогдсон болон олгогдоогүй бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаадаг бол*, олгогдсон бүрэлдэхүүн хэсгээс зээлийн үүргийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг Банк салгаж тодорхойлж чадахгүй: Банк нь хоёр бүрэлдэхүүн хэсгүүдэд нийлмэл нөөцийн санг толилуулдаг. Нийлмэл дүн нь олгогдсон хэсгийн дансны үнээс хасагдаж толилуулагдана. Дансны үнээс хэтэрсэн алдагдлын санг нөөцөөр бүртгэнэ; мөн
- *Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн хэрэглүүрүүд*: эдгээр хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээр бүртгэгдсэн байдаг тул санхүүгийн байдлын тайланд алдагдлын нөөц санг хүлээн зөвшөөрдөггүй. Алдагдлын нөөц санг бодит үнэ цэнийн нөөцөд хүлээн зөвшөөрдөг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл

(vi) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

Данснаас хасах

Зээл болон өрийн үнэт цаасыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөн авах үндэслэл бүхий хүлээлт байхгүй болсон үед данснаас хасдаг (бүхэлд нь эсвэл хэсэгчлэн). Энэ нь Банк зээлдэгчийг данснаас хасагдах хөрөнгийг төлөх хангалттай мөнгөн хөрөнгө эсвэл орлогын эх үүсвэр байхгүй гэж тодорхойлсон үед ихэвчлэн тохиолддог. Энэхүү үнэлгээг тусгайлсан хөрөнгийн түвшинд гүйцэтгэдэг.

Данснаас хассан хөрөнгүүдийн хувьд Банкны өр төлбөрөө нөхөн авах журмын дагуу төлүүлэх үйл ажиллагаа авч болно.

(vii) Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх нь

Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед нягтлан бодох бүртгэлийн үл нийцлийг үлэмж хэмжээгээр бууруулж эсвэл арилгахаар байвал Банк тодорхой санхүүгийн хөрөнгүүдийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилдаг.

Санхүүгийн өр төлбөр

Банк нь дараах тохиолдлуудад санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх гэж ангилж болно:

- дотооддоо бодит үнэ цэнийн сууриар тайлагнагдаж үнэлэгдсэн; эсвэл
- нягтлан бодох бүртгэлийн үл нийцлийг үлэмж хэмжээгээр бууруулж эсвэл арилгасан байх.

(в) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төв банкинд байршуулсан хязгаарлагдаагүй харилцах, бодит үнэ цэнийн өөрчлөлтөд бага өртдөг өндөр хөрвөх чадвартай санхүүгийн хөрөнгүүд ба богино хугацааны үүргүүдийг төлж барагдуулахад ашигладаг харилцах, хадгаламжаас бүрдэж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд хорогдуулсан өртгөөр илэрхийлэгддэг.

(г) Хөрөнгө оруулалтын үнэт цаас

Хөрөнгө оруулалтын үнэт цаас нь дараах зүйлсийг багтаана:

- Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалтын үнэт цаас; эдгээр нь анх бодит үнэ цэнэ дээр шууд нэмэгдэл зардлыг нэмж хүлээн зөвшөөрөгдөн, дараа үед үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг;
- Өрийн болон өмчийн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг заавал ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх эсвэл тодорхойлогдох гэж ангилж болно; эдгээрийг ашиг, алдагдлаар шууд хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийн хамт бодит үнэ цэнээр хэмжинэ;
- Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн өрийн үнэт цаас; болон
- Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн өмчийн хөрөнгө оруулалтын үнэт цаас.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(г) Хөрөнгө оруулалтын үнэт цаас, үргэлжлэл

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн, хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгөтэй ижил арга барилаар ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг дараахаас бусад өрийн үнэт цаасны хувьд, олз ба гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.

- Үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцсон хүүний орлого;
- Хүлээгдэж буй зээлийн алдагдал ба буцаалт; болон
- Гадаад валютын арилжааны олз ба гарз.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөх үед өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн байсан хуримтлагдсан олз, гарзыг өмчөөс ашиг, алдагдал руу дахин ангилна.

Банк арилжааны зорилгоор эзэмшдэггүй өмчийн хэрэглүүр дэх зарим хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогын өөрчлөлтөөр толилуулахаар сонгож болно. Энэхүү сонголтыг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хөрөнгө оруулалт тус бүрт хийж болох ба эргэн буцахгүй.

Ийм өмчийн хэрэглүүрийн олз, гарзыг ашиг, алдагдлаар дахин ангилахгүй ба үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөхгүй. Хөрөнгө оруулалтын зардлын зарим хэсгийг нөхнө гэж үзэхээс бусдаар ногдол ашгийг ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд тэдгээрийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг хөрөнгө оруулалтыг борлуулах үед хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.

(д) Үндсэн хөрөнгө

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах болон барьж байгуулахтай шүүд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой хэсгийн элэгдүүлэх хугацаа тухайн үндсэн хөрөнгөөс ялгаатай бол тэдгээрийг үндсэн хөрөнгийн тусдаа зүйл (гол бүрэлдэхүүн) гэж үзнэ.

Дараа үеийн зардал

Банк нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(д) Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглагдах жилийнх нь туршид шулуун шугамын аргаар тооцон байгуулдаг. Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дүнд багтсан гол бүрэлдэхүүн хэсгийн ашиглагдах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрт тусад нь элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассаны цэвэр орлогын зөрүүгээр үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз, гарзыг тухайн жилийн бусад үйл ажиллагааны бус орлого (зардал)-оор хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцүүлэх хугацаанд тооцсон эдийн засгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна:

	Ашиглагдах хугацаа (жилээр)
Тавилга, эд хогшил	10
Тээврийн хэрэгсэл	10
Компьютер, холбогдох хэрэгсэл	2-3

Элэгдэл тооцох арга, ашиглалтын жил болон үлдэх өртгийг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг ба шаардлагатай бол залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

(е) Биет бус хөрөнгө

Худалдан авсан программ хангамжийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэдэг. Программ хангамжийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх тохиолдолд холбогдон гарсан аливаа дараа үеийн зардлыг капиталжуулна. Бусад гарсан зардлуудыг гарсан тухай бүрд нь ашиг, алдагдлаар бүртгэдэг.

Программ хангамжийн хорогдуулгыг тэдгээрийг ашиглах боломжтой болсон өдрөөс нь эхлэн тооцсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцдог. Тайлант жилийн программ хангамжийн тооцоолсон ашиглагдах хугацаа нь 2-оос 3 жил байна. Тодорхой хугацаанд ашиглагдах биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон хорогдуулах аргыг тайлант үе бүрийн эцэст хянаж үздэг.

Бизнесийн нэгдлийн үр дүнд “одоогийн гэрээнүүд болон тэдгээртэй холбоотой харилцагчтай тогтоосон харилцаа холбоо”-г шинэ биет бус хөрөнгөөр тодорхойлсон. СТОУС 3 *Бизнесийн нэгдэл* болон НББОУС 38 *Биет бус хөрөнгө* –ийг тус тус баримтлан шинээр тодорхойлогдсон биет бус хөрөнгийг худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрсөн.

Гүүдвил

Гүүдвил нь бизнесийн нэгдэл дэх тодорхойлогдох боломжтой хөрөнгө, өр төлбөр болон хүлээн авсан болзошгүй өр төлбөр зэрэг Банкны ашиг сонирхлоос илүү гарсан бизнесийн нэгдлийн өртгийг харуулдаг. Энэхүү өртөг нь хүлээлгэн өгсөн хөрөнгө, хүлээн авсан өр төлбөр, гаргасан өмчийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэн дээр нэмэх нь нэгтгэгдэж байгаа талын хяналтын бус ашиг сонирхлын дүнгээс гадна, хэрвээ бизнесийн нэгдлийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн бол, нэгтгэгдэж буй талын одоогийн өмчийн ашиг сонирхлын бодит үнэ цэнийн нийлбэр байдаг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(е) Биет бус хөрөнгө, үргэлжлэл

Гүүдвил, үргэлжлэл

Болзошгүй өр төлбөрийг нэгтгэлийн өдрөөрх бодит үнэ цэнээр гүүдвیلیйн өртөгт шингээх ба хэрвээ болзошгүй өр төлбөрийг санхүүгийн өр төлбөрөөр ангилах бол дараа нь ашиг, алдагдлаар дахин хэмждэг. Бизнесийн нэгдлийн хувьд худалдан авалтын шууд өртгийг зардлаар шууд хүлээн зөвшөөрдөг.

Гүүдвیلیйг биет бус хөрөнгөөр капиталжуулах бөгөөд түүний дансны үнийн бууралтыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Тодорхойлох боломжтой хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэн нь төлсөн төлбөрийн бодит үнэ цэнээс хэтэрч байгаа үед тухайн илүүдэл дүнг худалдан авалтын өдрөөр ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүрэн кредитэлнэ.

(ё) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад Банкны санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэн буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцохдоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан ирээдүйн мөнгөн үрсгалын тооцоолсон дүнг өнөөгийн үнэ цэн хүртэл нь дискаунтчилдаг. Үнэ цэнийн бууралтыг шалгах зорилгоор тусад нь тооцоолох боломжгүй хөрөнгүүдийг бусад хөрөнгүүд буюу бүлэг хөрөнгийн (мөнгө бий болгогч нэгжүүд) орж ирэх мөнгөн үрсгалаас ихэнхдээ хамааралгүй, тасралтгүй ашигласнаар мөнгөний орох үрсгалыг бий болгодог хөрөнгийн хамгийн бага ангилалд нэгтгэн бүлэглэдэг.

Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд тайлагнадаг. Мөнгө бий болгогч нэгжийн түвшинд тодорхойлогдсон аливаа үнэ цэнийн бууралт нь гүүдвیلیйн дансны үнийг эхлээд бууруулах бөгөөд дараа нь мөнгө бий болгогч нэгж дэх бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Хөрөнгийн үнэ цэнийн гарз буурсан аль эсвэл гарз үүсээгүй шинж тэмдгийг хэмжихийн тулд өмнөх үеийн хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг тайлант жил бүр үнэлдэг.

Нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцооллд өөрчлөлт үүссэн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг буцаана. Үнэ цэнийн бууралтын гарзыг өмнөх жилүүдэд хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол элэгдэл буюу хорогдлыг хассаны дараа тодорхойлогдох байсан дансны үнээс тухайн хөрөнгийн дансны үнийг хэтрүүлэхгүй байхаар тооцож буцаана.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(ж) Хувьцаат капитал

(i) Энгийн хувьцаа

Энгийн хувьцаа нь эздийн өмчийн хэсэгт ангилагддаг. Энгийн хувьцаа болон хувьцааны опцион (худалдан авах эрх) гаргахад шууд холбогдон гарах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөлөлгүй цэвэр дүнгээр өмчийн хэсгийг бууруулах байдлаар хүлээн зөвшөөрдөг.

(ii) Нэмж төлөгдсөн капитал

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү гарсан дүнгээрх нийлүүлсэн хувь юм. Хувьцаа эзэмшигчдийн нэмэлтээр оруулсан хөрөнгөөс нэмж төлөгдсөн капитал үүсэж болно.

(iii) Бусад нөөц

Тусгай зориулалтын нөөц нь Монголбанкны шаардлагад нийцүүлж байгуулсан нөөц байна. Монголбанкны журам болон СТОУС-ийн дагуу тооцоолсон зээлийн эрсдэлийн сангийн зөрүүгээр тодорхойлогдоно. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт тооцоход тусгай зориулалтын нөөцийг өөрийн хөрөнгөд авч үзэхгүй.

(з) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

(i) Ажилчдын богино хугацааны тэтгэмж

Ажилчдын богино хугацаат тэтгэмж гэдэгт ажилтан Банкинд үзүүлсэн үйлчилгээнийхээ хариуд тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмжийг хэлнэ. Ажилтан нь тайлант үеийн турш Банкинд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн үйлчилгээний хариуд төлөгдөхөөр хүлээгдсэн ажилчдын богино хугацааны тэтгэмжийн дискаунтчилагдаагүй дүнг хүлээн зөвшөөрдөг.

(ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Хуулийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа банкууд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

(u) Хүү

Үр ашигт хүүний түвшин

Хүүний орлого ба зардлыг үр ашигт хүүний аргаар тооцож ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. “Үр ашигт хүү” гэдэг нь хүлээгдэж буй хугацаан дахь ирээдүйд төлөгдөх буюу хүлээн авах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэглүүрийн дансны үнэд дискаунтчилахад ашиглаж буй хүү юм:

- санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ; эсвэл
- санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг.

Худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай зээлийн хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүний түвшинг тооцоолохдоо Банк нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн дагуу ирээдүйн бүх мөнгөн урсгалыг тооцох боловч хүлээгдэж буй алдагдлыг тооцохгүй. Худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай зээлийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулсан үр ашигт хүүний түвшинг тооцон хүлээгдэж буй алдагдлын ирээдүйн мөнгөн урсгалыг тооцно.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(u) Хүү, үргэлжлэл

Үр ашигт хүүний тооцоололд гүйлгээний зардал, хураамж, төлбөр хийсэн эсвэл хүлээн авсан хугацаа зэрэг үр ашигт хүүний чухал хэсгүүд багтана. Гүйлгээний зардалд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах болон борлуулахтай шууд хамаарах нэмэгдэл зардал багтана.

Хорогдуулсан өртөг болон нийт дансны үнэ

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үндсэн төлөлтийг хасаж үр ашигт хүүний түвшинг ашиглан анхны болон эцсийн дүнгийн зөрүүгээр хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх эсвэл хасах ба санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй аливаа зээлийн алдагдлын санг тохируулсан дүнг хэлнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ нь хүлээгдэж буй аливаа зээлийн алдагдлын санг тохируулснаас өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг хэлнэ.

Хүүний орлого болон зардлын тооцоолол

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүний түвшин гэж санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөд тооцоолсон түвшинг хэлнэ. Хүүний орлого ба зардлыг тооцоолохдоо, үр ашигт хүүний түвшинг хөрөнгийн нийт дансны үнэ (хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй байх үед) дээр эсвэл өр төлбөрийн хорогдуулсан өртөг дээр тооцдог. Зах зээлийн хүүний түвшний хөдөлгөөнийг тусгахын тулд хөвөгч хүүтэй хэрэглүүрийн мөнгөн гүйлгээг дахин үнэлэх замаар үр ашигт хүүний түвшинг шинэчилдэг. Хейджийн тохируулгын хорогдуулалтыг хийж эхлэх өдрөөр бодит үнэ цэнийн хейджийн тохиргооны үр ашигт хүүний түвшинг мөн шинэчилдэг.

Гэсэн хэдий ч, анхны хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээлийн үнэ цэнийн бууралттай болсон санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүний орлого нь санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг дээр үр ашигт хүүний түвшинг ашигласнаар тооцоологдоно. Хэрэв тухайн хөрөнгө нь цаашид зээлийн үнэ цэнийн бууралтгүй болвол хүүний орлогын тооцоолол нь буцаад нийт дансны үнийн сууриар тооцоологдоно.

Санхүүгийн хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнийн бууралттай байсан бол санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүний орлого нь санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг дээр үр ашигт хүүний түвшинг ашигласнаар тооцоологдоно. Хөрөнгийн зээлийн эрсдэл сайжирсан ч хүүний орлогын тооцоолол нь нийт дүнгээр тооцох суурь руу эргэн буцахгүй.

Толилуулга

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогод үр ашигт хүүний аргаар тусгагдсан хүүний орлого нь дараах зүйлсийг багтаана:

- хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн хүү;
- бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн хэрэглүүрийн хүү;
- хүүний орлого, зардалд нөлөө үзүүлж байх хугацааны хүүний мөнгөн урсгалын өөрчлөлтийн мөнгөн урсгалын хейджид ангилсан үүсмэл хейджийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит хэмжээ;
- хүүгийн эрсдэлийн бодит үнэ цэнийн хейджид ангилсан үүсмэл хейджийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит хэмжээ; болон
- хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөрийн сөрөг хүү.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(и) Хүү, үргэлжлэл

Толилуулга, үргэлжлэл

Арилжаалах хөрөнгө ба өр төлбөрийн хүүний орлого, зардлыг нь Банкны арилжааны үйл ажиллагаанд томоохон нөлөөгүй гэж үзэж, арилжааны хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийн бусад бүх өөрчлөлтүүдтэй хамт цэвэр арилжааны орлогоор толилуулдаг.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хүүний орлого, зардал нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх бусад санхүүгийн хэрэглүүрийн цэвэр орлогоор толилуулагддаг.

(й) Хураамж ба шимтгэл

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүний салшгүй хэсэгт хамаарах хураамж ба шимтгэлийн орлого, зардал нь үр ашигт хүүний хэмжилтэд хамаардаг.

Бусад хураамж ба шимтгэлийн орлогод дансны үйлчилгээний хураамж, хөрөнгө оруулалтын удирдлагын хураамж, борлуулалтын хураамж, байршуулалт болон хөрвүүлэлтийн хураамж зэрэг орох бөгөөд холбогдох үйлчилгээг үзүүлэх үед нь хүлээн зөвшөөрдөг. Хэрэв зээлийг дуусгавар болох хугацаанаас нь өмнө авахаар төлөвлөөгүй бол зээлийн үүрэг хариуцлагын хураамжийг тухайн зээлийн үүрэг дуусах хүртэл шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

Банкны санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой харилцагчтай байгуулсан гэрээний хувьд гэрээний зарим хэсэг нь СТОУС 9-ийн хамрах хүрээнд, зарим хэсэг нь СТОУС 15-ын хүрээнд хамаарч болно. Ийм тохиолдолд, Банк эхлээд СТОУС 9-ийн хамрах хүрээнд хамаарах хэсгийг СТОУС 9-ийн дагуу салган хэмжиж, үлдсэн хэсэгт СТОУС 15-ыг мөрддөг.

Бусад хураамж, шимтгэл нь ажил гүйлгээ болон үйлчилгээний төлбөртэй голдуу хамааралтай ба тухайн үйлчилгээг авсан үед нь зардлаар бүртгэнэ.

(к) Арилжааны цэвэр орлого

Арилжааны цэвэр орлого нь хөрөнгө, өр төлбөрийг арилжих олз, гарзын зөрүүнээс бүрдэх ба хэрэгжсэн, хэрэгжээгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт, хүү, ногдол ашиг, гадаад валютын зөрүү зэргийг багтаана.

(л) ААБҮЦ-ээр хэмжигдсэн бусад санхүүгийн хөрөнгийн цэвэр орлого

ААБҮЦ-ээр хэмжигдсэн бусад санхүүгийн хэрэгслийн цэвэр орлого нь хейджийн шалгуур хангасан харилцаа, ААБҮЦ-ээр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөр зэргийн бүрэлдэхүүн болдоггүй эрсдэлийг удирдах зорилгоор эзэмшиж буй арилжааны бус дериватив болон зайлшгүй ААБҮЦ-ээр хэмжигдэх арилжааны бус хөрөнгүүдтэй холбоотой. Энэ нь бүхий л хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнэ эсвэл гадаад валютын зөрүүний бусад орлогыг багтаана.

(м) Түрээс

Гэрээг анх байгуулах үед Банк нь тухайн гэрээ нь түрээсийн гэрээ юу эсвэл түрээс агуулсан гэрээ юу гэдгийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь тодорхой төлбөр хүлээн авснаар тухайлсан хөрөнгийн хэрэглээг тодорхой хугацаанд хянах эрхийг олгож байвал тухайн гэрээг түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулсан гэрээ гэж үзнэ. Тухайн хөрөнгийг ашиглах эрхийн хяналт шилжсэн эсэхийг үнэлэхдээ Банк нь СТОУС 16-д заасан түрээсийн тодорхойлолтыг ашигласан.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(м) Түрээс, үргэлжлэл

(i) Банк түрээслэгч байх

Түрээсийн бүрэлдэхүүнийг агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Банк гэрээнд тусгасан үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хуваарилдаг. Салбар болон оффисын барилгын түрээсүүдийн хувьд Банк нь түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгах аргыг сонгоогүй ба түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг бүрэлдэхүүн хэсэг гэж бүртгэсэн.

Банк нь түрээс эхлэх өдөр ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хэмжих бөгөөд үүнийг түрээсийн эхний өдөр болон түүнээс өмнө хийсэн түрээсийн төлбөрөөр тохируулсан түрээсийн өр төлбөрийн анхны дүн, аливаа анхдагч шууд зардлууд болон хөрөнгийг буулгах, сэргээн засварлахад түрээслэгчээс гарах аливаа тооцоолсон өртөг, мөн түрээсийн урамшууллыг хассан дүнгээр илэрхийлдэг.

Түрээсийн хугацаа дуусгавар болох үед ашиглах эрхтэй хөрөнгийг худалдан авах сонголтыг гэрээнд заасан эсвэл түрээсийн хугацааны эцэст тухайн түрээсийн хөрөнгийн өмчлөх эрх Банкинд бүрэн шилжихээс бусад үед ашиглах эрхтэй хөрөнгийг гэрээ эхэлсэн өдрөөс дуусах өдөр хүртэл шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Энэ тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийг тухайн хөрөнгийн ашиглалтын жилээр элэгдүүлэх бөгөөд ашиглалтын жилийг үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тодорхойлох суурьтай ижил зарчмаар тодорхойлдог. Түүнчлэн, ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнийг аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлаар бууруулж, түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтээр тохируулдаг.

Түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ түрээсийн эхний өдрөөрх төлөгдөөгүй түрээсийн төлбөрүүдийг түрээст агуулагдсан нуугдмал хүүний хувь хэмжээ эсвэл уг хувь хэмжээг тодорхойлох боломжгүй бол Банкны өсөн нэмэгдэх зээлийн хүүний хувь хэмжээг ашиглан дискаунтлан өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Банк өсөн нэмэгдэх зээлийн хүүний хувь хэмжээг дискаунтын түвшин гэж авч үздэг.

Банк нь өсөн нэмэгдэх зээлийн хүүний хувь хэмжээг хэд хэдэн хөндлөнгийн эх үүсвэрээс хүүний хувь хэмжээг авах замаар тодорхойлдог бөгөөд түрээсийн нөхцөл, түрээсэлсэн хөрөнгийн төрлийг илэрхийлэх тодорхой тохируулгуудыг хийдэг.

Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд багтсан түрээсийн төлбөрт дараах зүйлсүүд багтдаг:

- тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр хамаарна);
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, эхний өдөр индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн анхны хэмжилтээр;
- үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүн; болон
- Банкны худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол уг сонголтыг хэрэгжүүлэх үнэ. Үүнд, Банк түрээсийг сунгана гэж үзвэл сунгалтын нэмэлт төлбөр, түрээсийн хугацааг эрт цуцлах торгууль зэрэг хамаарна.

Түрээсийн өр төлбөрийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хэрэв индекс эсвэл хувь хэмжээнээс шалтгаалан Банкны ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдөх, үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд өөрчлөлт орох, худалдан авалт хийх, сунгах эсвэл цуцлах эсэхэд өөрчлөлт орох эсвэл үндсэн түрээсийн төлбөрийг шинэчлэх тохиолдолд түрээсийн өр төлбөрийг дахин хэмждэг.

Түрээсийн өр төлбөрийг ийм байдлаар дахин хэмжихэд ашиглах эрхтэй хөрөнгийн дансанд холбогдох тохируулгыг хийдэг. Хэрэв ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ тэг болж буурсан байсан бол тохируулгыг ашиг, алдагдалд бүртгэдэг.

Банк нь санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхтэй хөрөнгийг 'үндсэн хөрөнгө'-ийн ангилалд, түрээсийн өр төлбөрийг 'бусад өр төлбөр'-ийн ангилалд бүртгэдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(м) Түрээс, үргэлжлэл

(i) Банк түрээслэгч байх, үргэлжлэл

Богино хугацааны түрээс ба бага өртөг бүхий түрээс

Банк бага үнэтэй хөрөнгийн түрээс болон богино хугацаат түрээсийн (үүнд мэдээлэл технологийн төхөөрөмж багтана) хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргыг сонгосон. Банк эдгээр түрээстэй холбоотой түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(ii) Банк түрээслүүлэгч байх

Түрээсийн бүрэлдэхүүнийг агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Банк гэрээнд тусгасан борлуулах үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хуваарилдаг.

Банк түрээслүүлэгчийн хувьд, түрээсийг санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс эсэхийг тодорхойлдог.

Түрээсийн ангиллыг тодорхойлохдоо Банк нь холбогдох хөрөнгийн эзэмшилтэй холбоотой эрсдэл болон өгөөжийн бараг бүгдийг нь шилжүүлсэн эсэхийг ерөнхий үнэлгээгээр шалгадаг. Хэрэв тийм тохиолдолд, түрээс нь санхүүгийн түрээс; үгүй бол үйл ажиллагааны түрээс байдаг. Энэхүү үнэлгээнд Банк нь хөрөнгийг эдийн засгийн ашиглах хугацааны ихээхэн хэсэгт түрээслүүлж буй эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үздэг.

Банк нь түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтад СТОУС 9-ийн үл хүлээн зөвшөөрөлт ба үнэ цэнийн бууралтын шалгууруудыг харгалзан үздэг. Банк нь түрээсийн нийт хөрөнгө оруулалтыг тооцоолоход ашиглагдах баталгаагүй үлдэгдэл үнэ цэнийг тогтмол хянаж байдаг.

(н) Орлогын албан татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардлаас бүрддэг. Тайлант үеийн татвар болон хойшлогдсон татварыг өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(i) Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашгийг тооцохдоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашгийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашгаас ялгаатай байдаг.

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг хөрөнгө, өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоорх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүн дээр үндэслэдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(н) Орлогын татвар, үргэлжлэл

(ii) Хойшлогдсон татвар, үргэлжлэл

Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг татвар ногдох орлого олсон үед татварын орлого ногдох нь тодорхой болсон бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө.

Дараах түр зөрүүнүүдэд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөггүй: гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт, эсвэл бизнесийн нэгдэл биш бөгөөд ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашиг/татварын алдагдлын аль алинд нөлөөлөхгүй ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед Банк хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон, эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Банк нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

Банк нь тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

Хэрэв ногдол ашиг төлөлттэй холбоотойгоор нэмэлт орлогын албан татварын зардал үүссэн бол уг орлогын албан татварын зардлыг ногдол ашгийн төлөлттэй холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед орлогын албан татварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

(о) Нөөцийн сан

Банк нь нөөцийн санг өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг хариуцлагын (хууль ёсны эсвэл бүтцийн) үед хүлээн зөвшөөрдөг бөгөөд Банк нь үүрэг хариуцлагыг барагдуулах шаардлагатай бөгөөд үүрэг хариуцлагын хэмжээгээр найдвартай тооцооллыг хийж болно.

Тайлагналын эцсийн үеийн үүрэг хариуцлагыг хүлээх шаардлагатай гэж үзсэн мөн үүрэг хариуцлагын эрсдэл ба тодорхойгүй байдлыг харгалзан үзсэн хамгийн сайн тооцооллоор нөөцийн санг хүлээн зөвшөөрдөг.

Нөөцийн санг өнөөгийн үүрэг хариуцлагыг хангах мөнгөн үрсгалыг ашиглан тооцоолсон үед үүний дансны үнэ нь эдгээр мөнгөн үрсгалуудын өнөөгийн үнэ цэнэ болдог (мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн нөлөө материаллаг бол).

Нөөцийн санг хангах бүх эсвэл зарим эдийн засгийн үр өгөөж нь гуравдагч талаас ирэх, хэрэв нөхөн олговор хүлээн авах нь тодорхой мөн авлагын дүнг найдвартай хэмжих боломжтой бол авлагыг хөрөнгөөр бүртгэнэ.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(ө) Санхүүгийн баталгаа болон зээлийн үүргүүд

“Санхүүгийн баталгаа” нь зээлдэгч өрийн хэрэглүүрийн нөхцөлийн дагуу төлбөрөө төлж барагдуулж чадаагүйгээс болж үүссэн алдагдлыг Банкнаас эзэмшигчид тодорхой төлбөрийг нөхөн төлөхийг шаарддаг гэрээ юм. “Зээлийн үүргүүд” нь урьдчилан тодорхойлсон нөхцөлийн дагуу зээл олгох амлалт үүргүүд юм.

Зах зээлийн хүүгээс бага хүүгээр олгогдох санхүүгийн баталгаа болон зээлийн үүргүүдийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед бодит үнэ цэнээр хэмждэг. Үүний дараа дараах зүйлсийн аль ихээр бүртгэнэ: СТОУС 9-ийн дагуу тодорхойлсон алдагдлын сан ба анхны хүлээн зөвшөөрөлтөөс СТОУС 15-ын дагуу хүлээн зөвшөөрсөн орлогын хуримтлагдсан дүнг хассан дүн.

Бусад зээлийн үүргүүдийн хувьд Банк нь алдагдлын нөөцийг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн баталгаа болон зээлийн үүргүүдээс гарсан өр төлбөрүүд нөөцийн санд багтсан байна.

(п) Холбоотой талууд

Энэхүү санхүүгийн тайлантай холбоотойгоор Банкны хувьд холбоотой талуудад дараах холбоо, харилцаа бүхий талууд багтана:

- i. Банкийг шууд эсвэл нэг буюу түүнээс дээш зуучлагчаар дамжуулан шууд бусаар хянадаг, санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын чанартай шийдвэрийг гаргахад Банкинд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвартай, эсвэл Банкийг хамтран хянадаг этгээд;
- ii. Банктай нэгдсэн нэг хяналтад байдаг этгээд;
- iii. Банкны эсвэл Банкны толгой компанийн гол удирдах ажилтан, эсвэл уг ажилтны гэр бүлийн ойр дотны гишүүн, эсвэл уг ажилтны хяналтад байдаг, хамтарсан хяналтад эсвэл мэдэгдэхүйц нөлөөнд байдаг аж ахуйн нэгж;
- iv. (i)-д дурдсан этгээдийн гэр бүлийн ойр дотны гишүүн, эсвэл уг гишүүний хяналтад байдаг, хамтарсан хяналтад байдаг эсвэл мэдэгдэхүйц нөлөөнд байдаг аж ахуйн нэгж; эсвэл
- v. Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч этгээд.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь Банктай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж магадгүй гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

5. Хүүний орлого ба зардал

Хүү болон түүнтэй адилтгах орлого

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Үр ашигт хүүний аргаар тооцсон хүүний орлого:		
Хорогдуулсан өртөөр илэрхийлэгдэх харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	72,333,216	43,947,878
Монголбанкны үнэт цаас	3,335,495	3,992,000
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	2,586,767	859,902
Үнэт металлын урьдчилсан хэлцэл	2,436,726	168,050
ХӨ-өөр илэрхийлэгдэх өрийн үнэт цаас	793,647	459,191
Монголбанк дахь харилцах, хадгаламж	415,351	132,299
	81,901,202	49,559,320
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого:		
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх урт хугацаат своп хэлцэл	2,652,310	665,853
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	325,208	547,302
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх өрийн үнэт цаас	243,412	42,265
	3,220,930	1,255,420
	85,122,132	50,814,740

Хүү болон түүнтэй адилтгах зардал

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Харилцагчдын харилцах, хадгаламж	25,240,229	14,540,727
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	12,942,407	5,509,409
Зээлээр авсан санхүүжилт	2,586,622	1,961,555
Урт хугацаат своп хэлцэл	2,534,030	601,835
Репо хэлцэл	1,711,197	1,574,259
Түрээсийн өр төлбөрийн хүүний зардал	942,274	694,188
	45,956,759	24,881,973

6. Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (зардал)

Дараах хүснэгтэд харилцагчтай байгуулсан гэрээний хураамж, шимтгэлийн орлогыг үйлчилгээний үндсэн төрлүүдээр харуулсан:

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Хураамж ба шимтгэлийн орлого		
Худалдааны санхүүжилтийн үйлчилгээний шимтгэл, хураамж	629,502	221,349
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	183,304	31,805
Картын үйлчилгээний шимтгэл, хураамж	179,250	43,847
Гүйлгээний хураамж	164,546	57,356
Зээлтэй холбоотой үйлчилгээ	27,473	3,422
Бусад үйлчилгээ	21,896	19,020
	1,205,971	376,799
Хураамж ба шимтгэлийн зардал		
Картын үйлчилгээний шимтгэл, хураамж	(462,385)	(155,953)
Банкны үйлчилгээний шимтгэл, хураамж	(219,782)	(72,606)
Бусад хураамж	(468,171)	(233,533)
	(1,150,338)	(462,092)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (зардал)	55,633	(85,293)

7. Арилжааны цэвэр орлого

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Гадаад валютын арилжааны олз	11,968,088	512,596
Гадаад валютын арилжааны гарз	(9,954,749)	(140,615)
Үнэт металл арилжааны олз	7,113,687	2,842,182
Үнэт металл арилжааны гарз	(5,176,785)	(1,794,708)
Үнэт цаас борлуулсны олз	109,594	38,303
Үнэт цаас борлуулсны гарз	(21,787)	(599)
	4,038,048	1,457,159

8. ААБҮЦ-ээр хэмжигдэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн бусад орлого (зардал)

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021 Дахин тайлагнасан
Дериватив хэлцлийн бодит үнэ цэнийн өөрчлөлт		
- Гадаад валют	(2,073,302)	8,832
- Үнэт металл	(1,129)	1,129
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх харилцагчид олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын гарз	127,909	(150,382)
Хувьцаагаарх хөрөнгө оруулалтын үнэлгээний өөрчлөлт	(870)	(37,475)
	(1,947,392)	(177,896)

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

9. Бусад орлого ба зардал

9.а Бусад орлого:

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Ханшийн зөрүүний цэвэр олз	3,180,742	-
Заавал байлгах нөөцийн урамшуулал	309,182	41,094
Бусад	46,118	13,558
	3,536,042	54,652

9.б Бусад зардал:

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Зар сурталчилгаа, маркетингийн зардал	1,165,890	501,804
Даатгалын зардал	725,125	231,921
Засварын зардал	665,495	468,363
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	644,023	547,132
Богино болон бага үнэтэй зүйлсийн түрээс	552,453	549,127
Харуул хамгаалалтын зардал	511,178	213,481
Хөдөлмөр хамгаалал	177,408	57,781
Мэдээлэл технологи, шуудан холбооны зардал	142,989	81,984
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	108,676	107,371
Бичиг хэрэг	98,150	103,561
Тээврийн зардал	80,122	30,965
Ашиглалтын зардал	73,174	32,642
Түрээсийн гэрээ цуцалсны гарз	1,058	-
Ханшийн зөрүүний цэвэр гарз	-	52,086
Бусад зардлууд	227,060	93,052
	5,172,801	3,071,270

10. Хүний нөөцийн зардал

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Цалин	9,008,996	4,860,686
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	1,156,858	540,547
Томилолтын зардал	137,102	17,927
Ажилчдын сургалтын зардал	30,695	11,350
Ажилчидтай холбоотой бусад зардлууд	80,572	12,640
	10,414,223	5,443,150

11. Үйл ажиллагааны бус зардал

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Торгууль	200,000	170,006
Зочин төлөөлөгчийн зардал	124,776	16,437
Хандивын зардал	3,720	4,483
Бусад	77,833	30,531
	406,329	221,457

12. Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтын (гарз) эсвэл буцаалт

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021 Дахин тайлагнасан
ХӨ-өөр илэрхийлэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 18)	(8,480,920)	(144,581)
Монголбанк дахь мөнгө	(671,106)	(334,246)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж (Тодруулга 15)	(97,040)	7,061
ХӨ-өөр хэмжих санхүүгийн хөрөнгө оруулалтууд	(68,590)	(39,023)
Бусад хөрөнгө	(58,101)	(1,330)
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх шинээр хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө	153,281	(164,975)
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө*	(77,363)	87,612
	(9,299,839)	(589,482)

*2022 онд Банк өмнө нь эзэмшиж байсан Монголбанкны үнэт цаасанд хамаарах бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн байсан 164,975 мянган төгрөгийн хуримтлагдсан олзыг (2021: 18,128 мянган төгрөг) холбогдох Монголбанкны үнэт цаасыг санхүүгийн тайланд үл хүлээн зөвшөөрсөнтэй холбоотойгоор ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилсан.

13. Орлогын албан татварын зардал

(1) Орлогын албан татварын зардал дараах байдалтай байна:

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021
Орлогын албан татвар		
Тайлант жилийн татварын зардал	2,410,060	2,806,988
Хойшлогдсон татварын зардал (өгөөж)	533,957	(366,013)
Өмнөх тайлант жилийн залруулга	15	-
	2,944,032	2,440,975

(2) Орлогын татварын зардал ба хуулиар тогтоосон татварын хувь хэмжээг ашиглаж тооцоолсон орлогын татварын уялдаа дараах байдалтай байна:

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022	2021 Дахин тайлагнасан
Татварын өмнөх ашиг	13,631,866	13,845,397
Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар (*)	2,507,967	2,561,349
Татвараас хасагдахгүй зардлын нөлөөлөл	816,418	101,501
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	(383,557)	(222,328)
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын нөлөөлөл	3,204	453
	2,944,032	2,440,975

13. Орлогын албан татварын зардал, үргэлжлэл

Эрсдэлийг бууруулах

Банк нь эрсдэлийг бууруулах, урьдчилсан хяналт тавих зорилгоор “хамгаалалтын гурван шугам”-ыг хэрэгжүүлж ажилладаг. Эрсдэлийн удирдлагын хорооны баталсан лимитүүдийн хүрээнд бизнес нэгжүүд өөрсдийн чиг үүргийн хүрээнд үүсэж болзошгүй эрсдэлийг удирдаж ажилладаг. Эрсдэлийн нэгжүүд үүсэж болзошгүй эрсдэлүүд, түүнийг бууруулах арга замууд, холбогдох бодлого, журам, лимитүүдийг боловсруулж, лимитийн хэрэгжилтийг хянаж, тайлагнан ажиллаж байна.

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл

Эрсдэлийн хэт төвлөрөл

Банк нь зээлийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээнд үр дүнтэй удирдах, төвлөрлийн эрсдэлийг боломжит түвшинд барьж ажиллахын тулд Монголбанкнаас гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллахаас гадна дотоод бодлого, журамдаа зээлийн эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүдийг нарийвчлан тусгаж, мөрдөж ажилладаг. Банкны дотооддоо мөрддөг зээлийн төвлөрлийн эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг дурьдвал:

- i. Нийт зээлийн багц нь активын 70%-иас хэтрэхгүй.
- ii. Аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-иас хэтрэхгүй.
- iii. Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн дүн нь тухайн Банкны өөрийн хөрөнгийн 5%-иас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-иас тус тус хэтрэхгүй.
- iv. Эдийн засгийн нэг салбарт байршуулах зээлийн дээд хэмжээ нийт зээлийн багцын 35%-иас хэтрэхгүй.
- v. Гадаад валютаар олгох зээлийн дээд хэмжээ нийт зээлийн багцын 30%-иас хэтрэхгүй.
- vi. Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмын дагуу тодорхойлсон томоохон зээлдэгчдэд олгох активын нийлбэр өөрийн хөрөнгийн 280%-иас хэтрэхгүй.
- vii. Нийт зээлийн эрсдэлийн сан чанаргүй зээлийн харьцаа 50%-иас буурахгүй.
- viii. Нийт чанаргүй зээл нь Банкны системийн дундаж үзүүлэлтээс хэтрэхгүй зэрэг юм.

Банк нь зээлийн төвлөрлийн эрсдэлээс гадна эдийн засгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн эрсдэл, зээлдэгчийн эрсдэл, барьцаа хөрөнгийн эрсдэл зэргийг чухалчлан авч үзэж хэмжилт, хяналт хийсний үндсэн дээр зээлийн эрсдэлийг удирддаг.

Барьцаа хөрөнгө болон зээлийн бусад сайжруулалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээ

Дараах хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцыг харуулсан байна. Эрсдэлд өртөж болох нийт багцыг барьцаа хөрөнгөөр эрсдэлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

	2022.12.31	2021.12.31
	Нийт багцын	Нийт багцын
	хэмжээ	хэмжээ
<i>(мянган төгрөгөөр)</i>		
Монголбанк дахь мөнгө	221,008,465	117,848,702
Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	321,818,852	37,585,022
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	4,748,884	2,832,448
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх хөрөнгө	640,791	69,765,709
ХӨ-өөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	6,889,076	10,348,243
Дериватив санхүүгийн хөрөнгө	3,813,582	35,712
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	556,700,648	433,651,455
Балансын нийт дүн	1,115,620,298	672,067,291
Болзошгүй өр төлбөр	11,267,698	16,938,972
Үүрэг амлалт	3,798,127	-
Балансын гадуурх нийт дүн	15,065,825	16,938,972
Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн	1,130,686,123	689,006,263

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Барьцаа хөрөнгө болон зээлийн бусад сайжруулалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээ, үргэлжлэл

Бодит үнэ цэнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулсан ба энэ нь ирээдүйд үнэ цэн өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ биш юм.

Аж үйлдвэрийн салбараарх эрсдэлийн төвлөрөл

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг (Тодруулга 18) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, нийт дүнгээр нь үзүүлэв:

	2022.12.31		2021.12.31	
	Нийт багцын хэмжээ	%	Нийт багцын хэмжээ	%
<i>(мянган төгрөгөөр)</i>				
Уул уурхай ба хайгуул	154,906,561	27%	154,637,000	36%
Барилга	117,138,769	21%	57,739,172	13%
Худалдаа	116,767,116	21%	92,492,189	22%
Тээвэр	86,987,607	15%	80,109,865	19%
Цахилгаан, эрчим хүч	7,112,737	1%	7,898,983	2%
Үл хөдлөх хөрөнгө	698,115	0%	548,065	0%
Харилцаа холбоо	-	0%	-	0%
Бусад	80,895,573	14%	37,726,280	9%
	564,506,478	100%	431,151,554	100%
Хуримтлагдсан хүүний авлага	11,327,798		6,179,352	
Үнэ цэнийн бууралтын нөөц	(29,454,420)		(19,312,492)	
Зээлийн хойшлогдсон орлого	(105,130)		(101,160)	
ХӨ-өөр илэрхийлэгдэх цэвэр зээл ба урьдчилгаа	546,274,726		417,917,254	
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх зээл ба урьдчилгаа /Орон сууцны зээл/	3,536,992		2,711,003	
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх зээл ба урьдчилгаа /ЖДБ зээл/	6,888,930		13,023,198	
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	556,700,648		433,651,455	

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Зээлийн чанарын шинжилгээ

Дараах хүснэгтэд хорогдуулсан өртгөөр Банкны зээлийн дотоод шатлалын дагуу хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн талаарх зээлийн чанарын мэдээллийг оруулсан. Онцгойлон заагаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгүүдийн дүн нь нийт дансны үнээр илэрхийлэгдсэн болно. Хүснэгтэд байгаа зээлийн үүрэг амлалт болон санхүүгийн баталгааны гэрээний дүн нь үүргээр хүлээгдсэн болон баталгаажсан дүнг тус тус илэрхийлсэн.

Тодруулга 4 (б)(vi)-д 1, 2 болон 3-р шатлалын талаар тайлбарласан.

(мянган төгрөгөөр)	2022			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа				
AA ангилал	23,759,092	2,989	-	23,762,081
A ангилал	181,395	-	-	181,395
BB ангилал	867,667	-	-	867,667
B ангилал	25,714,005	7,013,513	2,250,000	34,977,518
CC ангилал	81,592,434	72,864,453	18,315,287	172,772,174
C ангилал	98,014,826	80,379,376	5,318,067	183,712,269
DD ангилал	22,768,539	52,359,727	20,135,811	95,264,077
D ангилал	25,579,402	14,495,889	12,894,006	52,969,297
Алдагдлын сан	(2,003,445)	(3,418,079)	(24,032,896)	(29,454,420)
Хуримтлагдсан хүүний авлага	4,172,204	6,422,309	733,285	11,327,798
Зээлийн хойшлогдсон орлого	(80,607)	(17,267)	(7,256)	(105,130)
Дансны үнэ	280,565,512	230,102,910	35,606,304	546,274,726

(мянган төгрөгөөр)	2021			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа				
AA ангилал	9,571,940	-	35,548	9,607,488
A ангилал	3,000,081	-	29,130	3,029,211
BB ангилал	-	-	316,417	316,417
B ангилал	25,540,362	11,005,600	2,444,367	38,990,329
CC ангилал	27,852,300	302,839	1,311,256	29,466,395
C ангилал	76,133,192	8,212,727	808,016	85,153,935
DD ангилал	89,550,088	31,822,039	5,365,962	126,738,089
D ангилал	97,252,386	39,327,266	1,270,038	137,849,690
Алдагдлын сан	(8,210,017)	(4,581,411)	(6,521,064)	(19,312,492)
Хуримтлагдсан хүүний авлага	4,599,034	1,580,318	-	6,179,352
Зээлийн хойшлогдсон орлого	(84,558)	(16,379)	(223)	(101,160)
Дансны үнэ	325,204,808	87,652,999	5,059,447	417,917,254

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Зээлийн чанарын шинжилгээ, үргэлжлэл

Дараах хүснэгтэд харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хугацаа хэтрэлтийг 1, 2 болон 3 дугаар шатлалаар ангилан харуулсан.

(мянган төгрөгөөр)	2022			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн иргэдэд олгосон зээл ба урьдчилгаа				
30 хоног доторх хугацаа хэтрэлттэй	25,139,830	-	-	25,139,830
31-90 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	16,503	-	16,503
91-180 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	293,050	293,050
181-360 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	-	-
360-с дээш хоног хугацаа хэтрэлттэй	-	-	87,461	87,461
Нийт дүн	25,139,830	16,503	380,511	25,536,844
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн аж ахуйн нэгжид олгосон зээл ба урьдчилгаа				
30 хоног доторх хугацаа хэтрэлттэй	253,337,530	88,553,399	5,998,000	347,888,929
31-90 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	138,546,045	17,301,072	155,847,117
91-180 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	21,520,502	21,520,502
181-360 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	5,787,595	5,787,595
360-с дээш хоног хугацаа хэтрэлттэй	-	-	7,925,491	7,925,491
Нийт дүн	253,337,530	227,099,444	58,532,660	538,969,634
2021				
(мянган төгрөгөөр)	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн иргэдэд олгосон зээл ба урьдчилгаа				
30 хоног доторх хугацаа хэтрэлттэй	9,767,344	500,000	-	10,267,344
31-90 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	-	-
91-180 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	49,054	49,054
181-360 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	35,592	35,592
360-с дээш хоног хугацаа хэтрэлттэй	-	-	97,283	97,283
Нийт дүн	9,767,344	500,000	181,929	10,449,273
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн аж ахуйн нэгжид олгосон зээл ба урьдчилгаа				
30 хоног доторх хугацаа хэтрэлттэй	319,133,007	71,265,560	-	390,398,567
31-90 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	18,904,911	-	18,904,911
91-180 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	785,255	785,255
181-360 хоног доторх хугацаа хэтрэлттэй	-	-	7,156,454	7,156,454
360-с дээш хоног хугацаа хэтрэлттэй	-	-	3,457,094	3,457,094
Нийт дүн	319,133,007	90,170,471	11,398,803	420,702,281

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Зээлийн чанарын шинжилгээ, үргэлжлэл

<i>(мянган төгрөгөөр)</i>	2022			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Зээлийн үүрэг амлалт				
В ангилал	594,280	-	-	594,280
Алдагдлын сан	-	-	-	-
	594,280	-	-	594,280
Санхүүгийн баталгааны гэрээ				
В ангилал	10,294,738	-	189,340	10,484,078
Алдагдлын сан	-	-	(189,340)	(189,340)
	10,294,738	-	-	10,294,738
	2021			
<i>(мянган төгрөгөөр)</i>	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Зээлийн үүрэг амлалт				
В ангилал	5,348,036	-	-	5,348,036
Алдагдлын сан	-	-	-	-
	5,348,036	-	-	5,348,036
Санхүүгийн баталгааны гэрээ				
В ангилал	11,401,596	-	189,340	11,590,936
Алдагдлын сан	-	-	(189,340)	(189,340)
	11,401,596	-	-	11,401,596

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалтууд

Банк нь зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгийн хүрэлцээг хангаж ажилладаг. Дараах хүснэгтэд санхүүгийн хөрөнгүүдийн төрлийн дагуу барьцаа хөрөнгүүдийг ангилан харуулсан.

Зээлийн эрсдэлийн төрлүүд

	Шаардлагатай барьцаа хөрөнгийн хувь		Үндсэн барьцаа хөрөнгийн төрлүүд
	2022.12.31	2021.12.31	
Байгууллагын харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа			
Хөрөнгө оруулалтын зээл	100	100	Бүх төрлийн үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, орлого, техник тоног төхөөрөмж, ашигт малтмалын ашиглалтын лиценз, баталгаа, батлан даалт
Эргэлтийн хөрөнгийн зээл	100	100	Бүх төрлийн үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, орлого, техник тоног төхөөрөмж, ашигт малтмалын ашиглалтын лиценз, баталгаа, батлан даалт
Зээлийн шугам	100	100	Бүх төрлийн үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, орлого, техник тоног төхөөрөмж, ашигт малтмалын ашиглалтын лиценз, баталгаа, батлан даалт
Шаардлагатай барьцаа хөрөнгийн хувь			
		2022.12.31	2021.12.31
Иргэдэд олгосон зээл болон урьдчилгаа			
Орон сууцны зээл	100	100	Орон сууцны үл хөдлөх хөрөнгө
Кредит карт	100	100	Цалин болон бусад орлого
Хадгаламж барьцаалсан зээл	100	100	Хадгаламж
Хэрэглээний зээл	100	100	Цалин болон тээврийн хэрэгсэл

Иргэдэд олгосон зээл болон урьдчилгаа

Орон сууцны зээл	100	100	Орон сууцны үл хөдлөх хөрөнгө
Кредит карт	100	100	Цалин болон бусад орлого
Хадгаламж барьцаалсан зээл	100	100	Хадгаламж
Хэрэглээний зээл	100	100	Цалин болон тээврийн хэрэгсэл

Байгууллагын харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа

Банк нь зээл олгохдоо хуулиар хориглоогүй бөгөөд зээл хүсэгчийн хууль ёсны өмчлөлд байгаа болон итгэмжлэлээр шилжсэн үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгийг барьцаалдаг.

Хэрэв зээлдэгчийн барьцааны зүйл нь зээл, зээлийн хүүг төлөхөд хүрэлцэхгүй буюу тэдгээр нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангаж чадахгүй гэж үзвэл уг төлбөрийг бүрэн эсвэл хэсэгчлэн хариуцахаар гуравдагч этгээд барьцаа, батлан даалт, баталгаа гаргаж болдог.

Шаардлагатай барьцаа хөрөнгийн төрөл болон дүн нь зээлдэгчийн эсвэл батлан даагчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ болон олгосон зээлийн төрөл зэргээс хамаарна. Барьцаа хөрөнгийн төрөл, үнэ цэнийг тодорхойлохдоо Банк нь Зээлийн Хорооны барьцаа хөрөнгийн удирдамжийг дагаж мөрддөг.

Банк нь барьцаа хөрөнгийг бодитоор шалгаж, барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг байнга хянаж, үндсэн гэрээний дагуу нэмэлт барьцаа гаргахыг хүсэж, үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн зохистой харьцааг үнэлэх явцдаа барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг хянадаг.

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүн

Үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашигласан үзүүлэлт, таамаглал болон арга техник

Зээлийн эрсдэлийн нөлөө бүхий өсөлт

Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд мэргэжлийн байгууллагын эх сурвалжтай, үндэслэлтэй, нотлогдохуйц мэдээллүүдийг ашигладаг. Мөн Банкны түүхэн мэдээлэлд үндэслэн чанарын болон тоон үзүүлэлтэд шинжилгээ хийдэг.

Зээлийн эрсдэлийн нөлөө бүхий өсөлтийг дараах 3 шалгуураар хуваан авч үздэг. Үүнд:

- Дефолт болох магадлал дээр үндэслэсэн тоон үзүүлэлтийн тест (PD);
- Чанарын үзүүлэлтүүд; мөн
- тулгуур үзүүлэлтүүд: 30 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй санхүүгийн хөрөнгө нь 2 дугаар шатлал, 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй санхүүгийн хөрөнгө нь 3 дугаар шатлалын дагуу тус тус тодорхойлогдоно.

Зээлийн эрсдэлийн түвшин

Банк нь дефолт болох эрсдэлийг таамаглах боломжтой гэж тодорхойлсон төрөл бүрийн мэдээ болон дотоод аргачлалд үндэслэн зээлийг эрсдэлийн түвшингээр нь ангилдаг. Дефолт болох эрсдэлийг тодорхойлох хүчин зүйлс болох чанарын болон тоон үзүүлэлтийг ашиглан зээлийн эрсдэлийн түвшинг тодорхойлдог.

Зээлийн эрсдэл нэмэгдэхийн хэрээр дефолт болох эрсдэл нэмэгдэх байдлаар эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Жишээ нь: эрсдэлийн зэрэг АА болон А-ийн хоорондох дефолт болох эрсдэлийн зөрүү, эрсдэлийн зэрэг А болон ВВ-ийн хоорондох дефолт болох эрсдэлийн зөрүүгээс бага байдаг.

Зээл бүр зээлдэгчийн боломжит мэдээлэл дээр үндэслэгдэн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед зээлийн эрсдэлийн түвшингээр хуваагддаг. Зээл нь өөр эрсдэлийн зэрэгт шилжих боломжтой тул тайлант хугацаанд тооцооллыг хийж эрсдэлийн түвшинг хянадаг ба төлбөр хариуцагчийн санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтыг тооцоолоход санхүүгийн нөхцөл байдал, зээлийн ашиглалт, гэрээний нөхцөлийн өөрчлөлт, төлбөр төлөлтийн мэдээлэл, зээлдэгчийн орлогын тогтвортой байдал, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хууль хяналтын байгууллагын лавлагаа зэрэг мэдээллүүдийг авч үздэг.

Ковид-19 вирусын цар тахалтай холбоотойгоор зохицуулагч байгууллагаас зээлийн хугацааны ангилал хийх хоногийг сунгах, заасан хугацаанд багтаан активын бүтцийг өөрчлөх, ангиллыг хэвээр хадгалах, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүй байх зэрэг шийдвэрүүдийг шат дараатай гаргасан ба банк нь уг тушаалуудыг мөрдөж, зээлийн ангилал, үнэлгээ хийхдээ харгалзан үзсэн.

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүн, үргэлжлэл

Үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашигласан үзүүлэлт, таамаглал болон арга техник, үргэлжлэл

Байгууллагын зээлүүд	Иргэдийн зээлүүд	Бүх зээлүүд
<ul style="list-style-type: none"> Харилцагчийн зээлийн материалын байнгын хяналтын үеэр олж авсан мэдээлэл – жишээ нь: аудитлагдсан санхүүгийн тайлан, удирдлагын тайлан бүртгэл, төсөв болон төлөвлөгөө. Тухайлсан анхаарал хандуулах хэсэг нь: нийт ахиуц ашгийн түвшин, санхүүгийн хөшүүргийн харьцаа, өрийн харьцаа, гэрээний заалтын биелэлт, удирдлагын чанар болон удирдлагад орсон өөрчлөлт Зээлийн лавлах агентлагууд, хэвлэлийн нийтлэл болон гадаад зээлийн эрсдэлийн зэрэглэлийн өөрчлөлтийн мэдээлэл Зээлдэгчийн болон бизнесийн үйл ажиллагаа дахь улс төрийн, зохицуулалтын болон технологийн орчны бодит болон хүлээгдэж буй өөрчлөлтүүд 	<ul style="list-style-type: none"> Дотооддоо цуглуулсан харилцагчийн зан төлвийн мэдээлэл – жишээ нь: зээлийн картын хэрэглээ Худалдан авалтын боломжит байдлын матриц Салбарын стандарт зээллэгийн оноог хамруулсан зээлийн лавлагааны агентлагуудын гадаад мэдээ 	<ul style="list-style-type: none"> Төлбөр төлөлтийн мэдээлэл – энэ нь хугацаа хэтрэлт болон төлбөрийн үзүүлэлтүүдийн хувьсагчдыг агуулдаг Олгосон зээлийн хязгаарын ашиглалт Гэрээний нөхцөл өөрчлөх хүсэлт болон олголт Бизнес, санхүү мөн эдийн засгийн одоогийн болон ирээдүйн таамагласан өөрчлөлтүүд

Доорх хүснэгтэд PD-тэй холбоотой Банкны дотоод зээлийн үнэлгээний ангиллыг гадаад үнэлгээний агент Moody's-ийн зээлийн үнэлгээний ангилалтай хэрхэн уялдуулсныг харуулав.

Байгууллагын зээл

Банкны байгууллагын зээлийн багц нь банкууд, улсын секторын байгууллагууд, төрийн өмчит байгууллагууд, компаниуд болон бусад бизнесүүдэд олгосон зээл ба урьдчилгаанаас бүрдэнэ.

Ангилал	12 сарын жигнэсэн дундаж PD	Гадаад үнэлгээ
AA	4.83%	B3
A	4.83%	B3
BB	4.59%	Сaa1
B	4.59%	Сaa1
CC	8.89%	Сaa2
C	8.89%	Сaa2
DD	20.25%	Сaa3
F	37.61%	Ca-C

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүн, үргэлжлэл

Үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашигласан үзүүлэлт, таамаглал болон арга техник, үргэлжлэл

Иргэдийн зээл

Иргэдэд олгосон зээлийн багц нь орон сууцны зээл, хувийн зээл болон кредит картын зээлүүдээс бүрдэнэ.

Ангилал	12 сарын жигнэсэн дундаж PD
AA	4.83%
A	4.83%
BB	4.59%
B	4.59%
CC	8.89%
C	8.89%
DD	20.25%
D	20.25%
F	37.61%

PD-ийг тодорхойлох нь

Зээлдэгчийн ангилал нь дефолт болох магадлалын үндэслэл бөгөөд дефолт болох магадлалын талаарх мэдээллийг Банк олон үнэлгээний Moody's агентлагийн тайлангаас авч ашигласан болно.

Зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох нь

Тайлант жилийн эцэс бүрт Банк нь зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг үнэлдэг. Мэдэгдэхүйц хэмжээний зээлийн эрсдэл илэрсэн эсэх нь санхүүгийн хэрэглүүрийн шинж чанар болон зээлдэгчээс ихээхэн шалтгаалдаг.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн эсэхийг Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын үйл явцтай уялдсан чанарын хүчин зүйлст тулгуурлан үнэлж болно. Эдгээр нь тоон шинжилгээнд бүрэн тусгагдаагүй байж болно. Эдгээр нь тодорхой шалгуурыг өндөржүүлсэн зээлийн хувьд, тухайлбал анхаарал хандуулах зээлийн жагсаалтад орсон зээлүүдэд хэрэгжиж болно.

Ийм чанарын үзүүлэлтүүд нь шинжээчийн үнэлэмж болон холбогдох түүхэн туршлага дээр үндэслэсэн байдаг.

Үндсэн аргын хувьд хөрөнгө нь 30-аас дээшгүй хоногийн хугацаа хэтрэлттэй тохиолдолд Банк мэдэгдэхүйц хэмжээний зээлийн эрсдэл илэрсэн гэж үзнэ. Хугацаа хэтрэлттэй хоногийг тоолохдоо хамгийн анхны бүтэн төлөлт хийгдээгүй өдрөөс эхлэн тоолно. Хугацаа хэтрэлттэй хоногийг тооцохдоо зээлдэгчид олгосон хөнгөлөлтийн хугацааг тооцохгүй.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц зээлийн эрсдэлгүй гэдэг нь баталгаажвал санхүүгийн хэрэглүүрийн алдагдлын санг 12 сарын хүлээгдэж буй алдагдлын тооцооллоор тооцно. Мэдэгдэхүйц зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүд нь эрсдэлгүй гэж үзсэн ч чанарын үзүүлэлтээр тодруулбал хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх зэрэг нь болзошгүй дефолт байх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Зээлийн нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд шинэчлэгдсэн гэрээний нөхцөлийн дагуу хамгийн сүүлийн төлбөрийн гүйцэтгэлийг харгалзан үзсэнээр ашиглалтын хугацааны туршид хүлээн зөвшөөрөх хүлээгдэж буй эрсдэлийн шалгуурыг хангахгүй байж болно.

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүн, үргэлжлэл

Зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох нь, үргэлжлэл

Банк нь мэдэгдэхүйц зээлийн эрсдэлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн үр дүнг тогтмол хянаснаар доорх шалгуур үзүүлэлтүүдийг баталгаажуулна:

- шалгуур үзүүлэлт нь дефолт болох эрсдэлээс өмнө мэдэгдэхүйц зээлийн эрсдэлийг тодорхойлох чадамжтай байх;
- шалгуур үзүүлэлт нь хөрөнгийн 30 хоногийн хугацаа хэтрэлтийг цэг дээр давхцахгүй байх;
- мэдэгдэхүйц зээлийн эрсдэл болон дефолтын эрсдэлийг тодорхойлох дундаж хугацаа үндэслэл бүхий байх;
- санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл 12 сарын хүлээгдэж буй эрсдэлээс үнэ цэнийн бууралт руу шууд шилжихгүй байх;
- 12 сарын хүлээгдэж буй алдагдал (1-р шатлал) болон ашиглалтын хугацааны хүлээгдэж буй алдагдлын (2-р шатлал) хэмжилтийн хоорондох алдагдлын санд үндэслэлгүй шилжилт байхгүй байх.

Дефолтын тодорхойлолт

Банк нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд дефолт болсон гэж үзнэ:

- Төлбөрийн чадваргүй болох: Зээлдэгч дараах шалтгаанаар төлбөрийн чадваргүй болж болно:
 - Томоохон санхүүгийн хүндрэлд орох
 - Хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болох
 - Зээлдэгч зээлийн өр төлбөрөө төлж чадахгүйгээс болж дампуурлын улмаас зээлдэгч хөрөнгөө өөрчлөн байгуулах магадлал өндөр болсон үед
- 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй болох.

Банк нь зээлдэгчид дефолт үүсэх нөхцөл байгаа эсэхийг дараах шалгуураар үнэлнэ:

- чанарын үзүүлэлт – жишээ нь, гэрээг зөрчих;
- тоон үзүүлэлт – жишээ нь, хугацаа хэтрэлтийн байдал болон өөр бусад үүрэг хариуцлагыг Банкны өмнө хүлээхгүй байх; ба
- дотооддоо боловсруулсан мэдээлэл болон гадаад эх сурвалжаас олж авсан мэдээлэл.

Санхүүгийн хөрөнгө нь дефолт болох нөхцөл байдалд байгаа эсэх болон тэдгээрийн эрсдэлийн нөлөө нь цаг хугацааны туршид нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдан өөрчлөгдөж болно.

Ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашиглах нь

Банк нь санхүүгийн хэрэглүүрийн мэдэгдэхүйц зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш илэрсэн талаарх үнэлгээ болон хүлээгдэж буй алдагдлын хэмжилтийн үнэлгээнд ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Банк эдийн засгийн гурван хувилбарт нөхцөлийг тооцон үздэг: Банк нь эдийн засгийн гурван хувилбарт нөхцөлийг нэгдсэн түрүүлэгч индикатор ашиглан тооцсон ба утгыг итгэх завсар болон дундаж утгаас нь хамааруулан 3 түвшинд хуваахад эдийн засгийн нөхцөл байдлуудын суурь нөхцөл нь 37.36% (2021: 40.2%) бол магадлал бага хоёр хувилбар нь тус бүр 30.77% (2021: 31%) болон 31.87% (2021: 28.8%) магадлалтай байна. Суурь нөхцөл нь Банкны өөр бусад зорилго бүхий мэдээлэл болох стратегийн төлөвлөгөө, төсөв зэрэг бусад мэдээлэлтэй уялдсан байдаг. Банк сөрөг үр дагаварын хариуд эдийн засгийн өсөлт, бууралт, суурь тохиолдлын жигнэсэн дундаж хувилбарыг шинэчилж, цар тахлын дараах болон геополитикийн тэнцвэртэй бус байдлын нөлөөг илүү сайн тусгахын тулд шинэчилсэн хувилбаруудыг авч үзэн бусад мэдээллүүдтэй уялдуулсан.

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүн, үргэлжлэл

Зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох нь, үргэлжлэл

Өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгө

Зээлийн гэрээний нөхцөлүүд нь хэд хэдэн шалтгааны улмаас өөрчлөгдөж болох ба үүнд зах зээлийн нөхцөл, харилцагчийг тогтоох, харилцагчийн одоогийн болон боломжит зээлийн чанарын үзүүлэлт доошилсон эсэхэд хамаарахгүй бусад хүчин зүйлс орж болно. Хугацаа нь хэтрээгүй, бүтцийн өөрчлөлт хийгдээгүй тохиолдолд Түвшин 1 дэх зээл, 90 хоногийн дотор хугацаа хэтэрсэн, өөрчлөгдсөн зээлийг Түвшин 2 дахь зээл гэж ангилна. Хугацаа хэтэрсэн буюу 90-ээс дээш хоногийн хугацаатай зээлийг Түвшин 3-ийн зээл гэж үнэлнэ.

Зээлийн хүлээгдэж буй алдагдлын тооцоолол

Зээлийн хүлээгдэж буй алдагдлын тооцоололд дараах гол хувьсагчид хамаарна:

- Дефолт болох магадлал (PD);
- Дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ (LGD);
- Дефолт болсон үеийн дүн (EAD).

Түвшин 1 дэх зээлийн хүлээгдэж буй алдагдлыг 12 сарын хугацааны турших PD-г LGD болон EAD-ээр үржүүлэн тооцоолно. Ашиглалтын хугацааны туршид зээлийн хүлээгдэж буй алдагдлыг ашиглалтын хугацааны туршийн PD-г LGD болон EAD-ээр үржүүлэн тооцоолно.

LGD нь дефолт болох үеийн боломжит алдагдлын хэмжээ юм. Банк LGD-ийн хэмжигдэхүүнүүдийг тооцохдоо дефолт болсон харилцагч талуудын эсрэг нэхэмжлэлээс нөхөн төлөлт хийгдсэн түүхэн мэдээллийг харгалзан үздэг. LGD-ийн тооцоолол нь эдийн засгийн 3 хувилбарт дахин тохируулагддаг. LGD-ийг үр ашигт хүүний хэмжээг ашиглан дискаунтлагдсан мөнгөн гүйлгээний сууриар тооцоолдог.

EAD нь дефолт болох үеийн зээлийн хүлээгдэж буй дүнг илэрхийлнэ. Харилцагчийн одоогийн зээлийн дүн болон гэрээний хүрээнд өөрчлөгдөж болох, мөн хорогдуулалтаас үүсэх одоогийн үнэ цэнийн боломжит өөрчлөлтүүдээс EAD-г үүсгэдэг. Санхүүгийн хөрөнгийн EAD нь дефолт болох үеийн нийт дансны үнийг илэрхийлдэг. Зээлийн үүргийн хувьд EAD нь түүхэн ажиглалт болон ирээдүйн таамаглал дээр тулгуурлан тооцогддог гэрээний дагуух ирээдүйн боломжит дүн юм. Санхүүгийн баталгааны хувьд EAD нь санхүүгийн баталгааны төлбөр үүсэх баталгааны эрсдэлийг илэрхийлдэг.

Дээр дурдсанчлан, 12 сарын хугацааны турших хамгийн өндөр PD-г ашиглах Түвшин 1 дэх санхүүгийн хөрөнгийн хувьд, зээлийн эрсдэлийн удирдлагын зорилгоор урт хугацааг авч үзсэн ч Банк нь зээлийн эрсдэлд өртөх хамгийн урт гэрээний хугацаа (зээлдэгчийн хугацаа сунгах сонголтыг хамруулан) бүхий зээлийн дефолт болох эрсдэлийг авч үздэг.

Гэсэн хэдий ч, зээл болон олгогдоогүй зээлийн үүргийн бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаадаг иргэдийн богино хугацааны зээл, зээлийн картын хувьд, хэрэв Банкны эргэн төлөлтийг шаардах боломж болон олгогдоогүй үүргийг цуцлах нь гэрээний сануулгын хугацаа хүртэлх зээлийн алдагдлын дүнг хязгаарладаггүй бол Банк нь хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг гэрээний хамгийн урт хугацаанаас илүү урт хугацаанд хэмждэг.

Эдгээрт тогтмол хугацаа болон эргэн төлөлтийн бүтэц байдаггүй ба бүлгийн сууриар зохицуулагддаг. Банк нь эдгээрийг шууд цуцалж болох боловч энэхүү гэрээний эрх нь өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилт биш бөгөөд зөвхөн бүтээгдэхүүний түвшинд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц нөлөө илэрсэн тохиолдолд хэрэгждэг. Энэхүү урт хугацаа нь хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн Банкны хэрэгжүүлэх зээлийн эрсдэлийн үйл ажиллагааны хүрээнд тооцоологддог. Эдгээрт хязгаарыг бууруулах, бүтээгдэхүүнийг цуцлах эсвэл зээлийн үлдэгдлийг тогтмол төлөлттэй зээлд хөрвүүлэх зэрэг багтана.

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлаас үүсэх дүн, үргэлжлэл

Зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох нь, үргэлжлэл

Зээлийн хүлээгдэж буй алдагдлын тооцоолол, үргэлжлэл

Банк хязгаарлагдмал түүхэн мэдээлэлтэй учир дотооддоо бэлэн мэдээллийг дэмжих гадаад жишиг мэдээлэл ашигладаг. Зээлийн хүлээгдэж буй алдагдлын тооцоололд нөлөөлөхүйц оролцоотой гадаад жишиг мэдээллүүд:

Ашиглагдсан гадаад жишиг мэдээлэл	
PD	LGD
- Moody's-ийн Байгууллагын дефолт болон нөхөлтийн түвшин, 1983-2021	- Moody's-ийн Байгууллагын дефолт болон нөхөлтийн түвшин, 1983-2021
- Moody's-ийн structured түвшний шилжилт, 2020 оны 10 дугаар сар	- Basel-ийн Тоон нөлөөний судалгаа 3, Техникийн удирдамж, LGD сангийн арга аргачлал
- Moody's-ийн structured түвшний шилжилт, 2021 оны 10 дугаар сар	

Үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөц

Дараах хүснэгтэд санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөцийн эхний болон эцсийн үлдэгдлийг ангиллаар тохируулсныг харуулав.

(мянган төгрөгөөр)	2022			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа				
01 сарын 01-нээрх үлдэгдэл	8,210,017	4,581,411	6,521,064	19,312,492
Түвшин 1-д шилжсэн	26,182	(26,182)	-	-
Түвшин 2-т шилжсэн	(4,174,120)	4,174,120	-	-
Түвшин 3-т шилжсэн	(688,236)	(545,160)	1,233,396	-
Үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөцийн дахин хэмжилт	(758,745)	(4,097,486)	17,355,864	12,499,633
Үүссэн болон худалдан авсан шинэ санхүүгийн хөрөнгүүд	1,236,361	411,800	2,056,816	3,704,977
Үнэ цэнийн бууралтын нөөцийн буцаалт	(1,848,014)	(1,080,424)	(3,134,244)	(6,062,682)
12 сарын 31-нээрх үлдэгдэл	2,003,445	3,418,079	24,032,896	29,454,420

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.2 Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөц, үргэлжлэл

(мянган төгрөгөөр)	2021			Нийт
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	
Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа				
01 сарын 01-нээрх үлдэгдэл	796,855	4,320,211	11,356,676	16,473,742
Түвшин 1-д шилжсэн	869,990	(869,990)	-	-
Түвшин 2-т шилжсэн	(32,211)	32,211	-	-
Түвшин 3-т шилжсэн	(1,299)	(36,023)	37,322	-
Үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөцийн дахин хэмжилт	442,300	286,310	1,480,888	2,209,498
Үүссэн болон худалдан авсан шинэ санхүүгийн хөрөнгүүд	7,151,595	3,491,576	316,119	10,959,290
Үнэ цэнийн бууралтын нөөцийн буцаалт	(1,017,213)	(2,642,884)	(6,669,941)	(10,330,038)
12 сарын 31-нээрх үлдэгдэл	8,210,017	4,581,411	6,521,064	19,312,492

35.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Банк харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдал үүсэхийг төлбөрийн чадварын эрсдэл гэж үзнэ. Банк нь төлбөрийн чадварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахаас гадна төлбөрийн чадварын стресс тест сар тутам тооцож ЭУХ-д тайлагнаж ажилладаг.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.3 Төлбөрийн чадварын эрсдэл, үргэлжлэл

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар хийсэн шинжилгээ

Доорх хүснэгтэд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөрүүдийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүргүүд дээр үндэслэн харууллаа. Банкны харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүд дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн үрсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

(мянган төгрөгөөр)	2022 оны 12 сарын 31						
	Хугацаагүй	6 сар хүртэл	6 сараас 1 жил хүртэл	1-ээс 5 жил	5-аас дээш жил	Дискаунтлаагүй нийт дүн	Дансны үнэ
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	10,386,051	349,062,543	13,226,287	3,921,446	-	376,596,327	374,088,532
Харилцагчдын харилцах, хадгаламж	130,130,579	154,303,167	145,398,417	115,893,641	-	545,725,804	525,090,994
Репо хэлцэл	-	3,514,039	-	3,025,697	-	6,539,736	6,019,946
Зээлээр авсан санхүүжилт	-	17,404,411	15,060,066	8,264,541	-	40,729,018	40,696,557
Дериватив санхүүгийн өр төлбөр	-	4,210,856	418,940	1,172,337	-	5,802,133	5,839,782
Түрээсийн өр төлбөр	-	2,280,466	2,326,148	15,560,600	-	20,167,214	14,424,263
Бусад өр төлбөр	2,349,538	4,111,973	2,793,515	-	-	9,255,026	9,255,026
Баталгаа	310,109	6,120,896	1,615,417	2,437,656	-	10,484,078	10,484,078
Зээлийн үүрэг	549,280	5,000	-	40,000	-	594,280	594,280
Нийт	143,725,557	541,013,351	180,838,790	150,315,918	-	1,015,893,616	986,493,458

Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас харна уу.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.3 Төлбөрийн чадварын эрсдэл, үргэлжлэл

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар хийсэн шинжилгээ, үргэлжлэл

<i>(мянган төгрөгөөр)</i>	2021 оны 12 сарын 31						
	Хугацаагүй	6 сар хүртэл	6 сараас 1 жил хүртэл	1-ээс 5 жил	5-аас дээш жил	Дискаунтлагүй нийт дүн	Дансны үнэ
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	1,695,309	79,799,274	9,789,998	315,270	-	91,599,851	90,063,973
Харилцагчдын харилцах, хадгаламж	60,056,656	120,829,175	103,581,215	49,550,520	3,511	334,021,077	318,303,255
Репо хэлцэл	-	76,896,454	-	-	-	76,896,454	76,731,558
Зээлээр авсан санхүүжилт	-	3,577,149	41,920,253	3,825,591	-	49,322,993	47,066,560
Дериватив санхүүгийн өр төлбөр	-	20,009	-	-	-	20,009	20,009
Түрээсийн өр төлбөр	-	1,835,226	1,156,786	2,418,541	-	5,410,553	4,724,401
Бусад өр төлбөр	2,545,667	-	-	10,129,917	-	12,675,584	12,675,584
Баталгаа	972,781	8,727,313	401,502	1,300,000	-	11,401,596	11,401,596
Зээлийн үүрэг	328,036	-	5,020,000	-	-	5,348,036	5,348,036
Нийт	65,598,449	291,684,600	161,869,754	67,539,839	3,511	586,696,153	566,334,972

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас Банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэгслийн үнэлгээнд өөрчлөлт орж, хохирол хүлээх эрсдэлийг зах зээлийн эрсдэл гэж үзнэ.

Хүүний түвшний эрсдэл

Хүүний түвшний эрсдэл гэдэг нь Банкны эзэмшиж буй хүүний өөрчлөлтөд мэдрэмжтэй позицууд хоорондоо зөрүүтэй байх үед зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн улмаас Банкны орлого ба эдийн засгийн өртөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг хэлнэ. Зах зээлийн хүүний өөрчлөлтөөс Банкны хүүнд мэдрэмжтэй хөрөнгө, өр төлбөрийн зөрүүнээс хүлээх алдагдал нь Банкны төсөвлөсөн цэвэр хүүний орлогод шууд нөлөөлдөг. Зах Зээлийн Эрсдэлийн Удирдлагын Газраас хүүний өөрчлөлтөөс үүсэж болох хүүнд мэдрэмжтэй хөрөнгө, өр төлбөрийн зөрүүнээс хүлээх алдагдлын Банкны төлөвлөсөн цэвэр хүүний орлогод харьцуулсан харьцааг долоо хоног тутам тооцож АПУХ-нд танилцуулдаг. Мөн хүүний стресс тестийг сар тутам тооцож ЭУХ-нд тайлагнадаг ба хүүний эрсдэлийн түвшинг Эрсдэлийн Хорооноос баталсан хязгаарын хүрээнд хянан ажилладаг.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас гадаад валютын нээлттэй позицацийн үнэлгээ болон гадаад валютын арилжааны үр дүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг гадаад валютын ханшийн эрсдэл гэж үзнэ. Банк нь гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажиллахаас гадна Хамгийн их эрсдэлийн арга (VAR)-аар тухайн өдрийн нээлттэй позицоос алдаж болох хамгийн их алдагдлын хэмжээг өдөр бүр хэмжиж, иргэн, гадаадын болон дотоодын банк, байгууллагуудтай хийх арилжааны хэмжээ, арилжаа, ханшийн тэгшитгэлээс хүлээх алдагдлыг ЭУХ-оос баталсан хязгаарын хүрээнд хянаж ажилладаг. Хязгаарын хэрэгжилтийг АПУХ-нд тайлагнаж ажилладаг бол гадаад валютын ханшийн эрсдэлийн стресс тестийг ЭУХ-нд танилцуулдаг.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.4 Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2022 оны 12 дугаар сарын 31-ний болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

2022 оны 12 сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

	Тод	Төгрөг	Ам.доллар	Евро	Бусад	Нийт
Санхүүгийн хөрөнгө						
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь мөнгө	14	70,766,006	142,928,465	3,666,430	13,448,677	230,809,578
Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, Хадгаламж	15	127,733,347	162,501,196	20,419,395	11,164,914	321,818,852
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	4,748,884	-	-	-	4,748,884
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх хөрөнгө	16	640,791	-	-	-	640,791
ХӨ-өөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	6,889,076	-	-	-	6,889,076
Дериватив санхүүгийн хөрөнгө	17	3,813,582	-	-	-	3,813,582
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	496,994,382	55,724,139	166,123	3,816,004	556,700,648
Бусад хөрөнгө	23	4,778,138	1,037,032	111,212	310,293	6,236,675
		716,364,206	362,190,832	24,363,160	28,739,888	1,131,658,086
Санхүүгийн өр төлбөр						
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	24	250,058,965	123,585,559	548	443,460	374,088,532
Харилцагчдын харилцах, хадгаламж	25	284,765,319	204,923,741	17,313,569	18,088,365	525,090,994
Репо хэлцэл	26	6,019,946	-	-	-	6,019,946
Зээлээр авсан санхүүжилт	27	16,058,045	11,061,847	7,457,334	6,119,331	40,696,557
Дериватив санхүүгийн өр төлбөр	17	5,839,782	-	-	-	5,839,782
Бусад өр төлбөр	28	23,305,998	249,415	8,762	115,114	23,679,289
		586,048,055	339,820,562	24,780,213	24,766,270	975,415,100
Цэвэр позиц		130,316,151	22,370,270	(417,053)	3,973,618	156,242,986

Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас харна уу.

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.4 Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

2021 оны 12 сарын 31-ний байдлаар

(мянган төгрөгөөр)

	Тод	Төгрөг	Ам.доллар	Евро	Бусад	Нийт
Санхүүгийн хөрөнгө						
Бэлэн ба Монголбанк дахь мөнгө	14	100,083,413	10,496,497	8,142,917	4,024,767	122,747,594
Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, Хадгаламж	15	15,973,806	20,453,788	715,091	442,337	37,585,022
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	2,832,448	-	-	-	2,832,448
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх хөрөнгө	16	69,765,709	-	-	-	69,765,709
ХӨ-өөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	16	10,348,243	-	-	-	10,348,243
Дериватив санхүүгийн хөрөнгө	17	35,712	-	-	-	35,712
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	364,624,999	66,443,586	2,582,870	-	433,651,455
Бусад хөрөнгө	23	17,133,197	750,353	56,833	16,788,485	34,728,868
		580,797,527	98,144,224	11,497,711	21,255,589	711,695,051
Санхүүгийн өр төлбөр						
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	24	69,291,305	20,772,063	517	88	90,063,973
Харилцагчдын харилцах, хадгаламж	25	241,224,257	48,000,508	8,306,430	20,772,060	318,303,255
Репо хэлцэл	26	76,731,558	-	-	-	76,731,558
Зээлээр авсан санхүүжилт	27	30,453,017	13,344,464	3,269,079	-	47,066,560
Дериватив санхүүгийн өр төлбөр	17	20,009	-	-	-	20,009
Бусад өр төлбөр	28	16,279,379	1,112,449	7,778	379	17,399,985
		433,999,525	83,229,484	11,583,804	20,772,527	549,585,340
Цэвэр позиц		146,798,002	14,914,740	(86,093)	483,062	162,109,711

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил
35. Эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

35.4 Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

Урьдчилан төлөлтийн эрсдэл

Урьдчилан төлөлтийн эрсдэл гэдэг нь үйлчлүүлэгчид болон харилцагч байгууллагууд нь хүлээгдэж байснаас эрт эсвэл хойно төлбөрөө буцаан төлөх эсвэл төлбөр хийхийг хүссэний улмаас Банк санхүүгийн алдагдалд орох эрсдэл юм.

Банк нь төрөл бүрийн түвшний урьдчилан төлөлтүүдийн хүүний цэвэр орлогод үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолохдоо хялбаршуулсан аргыг авч хэрэглэдэг.

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь үйл ажиллагааны процесс, хүний болон системийн, гадаад үйл явдлуудын хангалтгүй байдал эсвэл доголдол гарснаас шалтгаалан алдагдал хүлээх эрсдэлийг хэлнэ. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд “Хамгаалалтын гурван шугам”-ыг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд хамгаалалтын нэгдүгээр шугам, эрсдэл ба хяналтын удирдлага буюу эзэн нь өдөр тутмын үйл ажиллагаанд эрсдэлийг олж илрүүлэх, үнэлгээ хийх, арга хэмжээ авах эрсдэлийг удирдан ажиллах чиг үүрэгтэй; хамгаалалтын хоёрдугаар шугам, эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлэгч нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийг удирдах бодлого, журам, стандарт, арга аргачлалыг боловсруулж 1-р шугамд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй; хамгаалалтын гуравдугаар шугам, хараат бус баталгаажуулалтыг хэрэгжүүлэгч нэгж нь 1-р шугамын эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдал, 2-р шугамын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг тус тус шалгаж дүгнэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

36. Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

Банк бизнесийн эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан идэвхтэй удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

Өөрийн хөрөнгийн удирдлага

Монголбанк нь өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг нийт арилжааны банкуудад тавьж, хянадаг.

Өөрийн хөрөнгөнд суурилан тооцсон өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 12 хувиас багагүй (2021 оны 12 дугаар сарын 31: 12%) байлгахыг шаардсан бөгөөд 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн нийт хөрөнгө 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9 хувиас багагүй байна (2021 оны 12 дугаар сарын 31: 9%).

Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна:

36. Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, үргэлжлэл

(мянган төгрөгөөр)	2022.12.31	2021.12.31
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	185,146,902	182,544,775
2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	-	-
1 ба 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	185,146,902	182,544,775
Эрсдэлээр жигнэсэн актив	661,446,118	544,774,977

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт:

Эрсдэлээр жигнэсэн активын хувиар илэрхийлсэн нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувь	27.99%	33.51%
Эрсдэлээр жигнэсэн активын хувиар илэрхийлсэн 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувь	27.99%	33.51%

2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх эрсдэлээр жигнэсэн активыг эрсдэлийн ангилалд дараах байдлаар хуваарилна:

%	2022.12.31		2021.12.31	
	Эрсдэлийн хөрөнгө	Жигнэсэн	Эрсдэлийн хөрөнгө	Жигнэсэн
0	234,137,830	-	205,695,037	-
20	138,131,834	3,888,096	20,865,106	4,173,021
50	17,810,914	8,905,457	2,944,004	1,472,002
100	671,252,595	497,651,564	432,590,934	432,590,934
150	100,667,334	151,001,001	71,026,013	106,539,020
Нийт	1,162,000,507	661,446,118	733,121,094	544,774,977

37. Тайлант үеийн дараах үйл явдал

Тээвэр Хөгжлийн Банкны Япон улсын Токио хот дахь Төлөөлөгчийн газар

Банкны үйл ажиллагааг тэлж, зах зээлийн эзлэлтийг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд Банк нь олон улсад банкны үйл ажиллагааг сурталчлах, корреспондент банкны харилцааг өргөжүүлэн, бэхжүүлэх, Монгол улсын эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, давуу талыг гадаад улсын байгууллага, бизнес эрхлэгчдэд түгээх зорилт тавин Япон улсын Токио хот дахь Төлөөлөгчийн газрыг байгуулахаар 2022 оны 10 сараас ажиллаж эхэлсэн. Япон улсын “Санхүүгийн Үйлчилгээний Агентлаг”-ийн 2022 оны 12-р сарын 09-ний өдрийн зөвшөөрөл, Монголбанкны 2023 оны 01-р сарын 25-ны өдрийн зөвшөөрөлд тус тус үндэслэн Монгол болон Япон улсын хууль, тогтоомжийн дагуу тус үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэхээр ажиллаж байна.

Тайлант жил дуусгавар болсноос хойш болон энэхүү санхүүгийн тайланг бэлтгэн, гаргахаар зөвшөөрөх хүртэл хугацаанд эдгээр санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэх өөр үйл явдал гараагүй гэж Банкны удирдлага үзэж байна.

38. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Англи болон Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Англи болон Монгол хувилбарын хооронд утга агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувилбарыг баримтална.